

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРТ  
ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРТ ХАМААРАХ  
ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАНГИЙН  
ТАНИЛЦУУЛГА /2020 оны жилийн эцсийн байдлаар/**

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Монгол Улсын Их Хурлын 2020 оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24, Засгийн газрын 2020 оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” 203 дугаар тогтоолд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний 2020 оны хэрэгжилтийг тухайн онд тавьсан зорилт, хүрэх түвшин, шалгуур үзүүлэлттэй харьцуулан тооцож, үр дүнг үнэлэн, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулж, удирдлагыг үнэн бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

**ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНДЭСЛЭЛ, ҮНЭЛГЭЭНИЙ АРГА ЗҮЙ**

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов. Ингэхдээ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн 2020 оны жилийн эцсийн тайланг судлах, Монгол Улсын болон барааны экспорт, импортын статистикийн 2020 оны гүйцэтгэлийн урьдчилсан мэдээлэлтэй тулгаж шалгах, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцах, тодруулга авах арга хэлбэрээр хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын бодит үр дүнг хүрэх түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж, зорилтын хэрэгжилтийг дараах ангилалд шилжүүлэн тооцлоо. Үүнд: “үр дүнтэй” – 100.0%, “тодорхой үр дүнд хүрсэн” – 70.0 - 99.0%, “эрчимжүүлэх шаардлагатай” – 31.0 - 69.0%, “үр дүнгүй” – 0.0 - 30.0% үнэлгээг гаргалаа.

**ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах 4 зорилтын 57 арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Зорилтын дундаж үнэлгээгээр тодорхой үр дүнд хүрсэн - 76.54 хувь байна. (Хүснэгт 1)

**Зорилт тус бүрийн хэрэгжилтийн үр дүн**

№	Зорилтын нэр	Арга хэмжээний тоо	Дундаж үнэлгээ
1	Ковид-19 халдварт цар тахлаас үүдэлтэй нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах бодлого	1	70.0
2	Эдийн засгийн бодлого	54	77.08
3	Засаглалын бодлого	1	70.0
4	Ногоон хөгжлийн бодлого	1	70.0
Зорилтын дундаж		57	76.54

**Арга хэмжээний хяналт-шинжилгээ, үнэлгээний чанарын үзүүлэлт**

Үнэлгээ	Арга хэмжээ	
	Тоо	Эзлэх хувь
100	6	10.53
90	14	24.56
70	27	47.37
50	4	7.02
30	1	1.75
0	-	-
Үнэлэх боломжгүй	5	8.77
Дүн	57	100.0

Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн  
хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн  
2020 оны жилийн эцсийн үр дүн

3.3. Хөдөө аж ахуй бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос бүрэн хангаж, импортыг орлох болон экспортын баримжаатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжинэ.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	2021 он	Хүрсэн түвшин	Хэрэгжилтийн үр дүн
1	Хүнсний ногооны хангамж	хувь	40	55	44.6	30.7%
2	Төмсний хангамж	хувь	100	100	100.0	100.0%
3	Буудайн хангамж	хувь	100	100	83.0	83.0%
4	Махны нөөц бүрдүүлсэн хэмжээ	мян.тонн	11	20	8.0*	0.0%
5	Мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ	мян.тонн	59	70	38.6*	0.0%
6	Сэрүүний улиралд нийлүүлсэн сүү	сая.литр	17	20	17.5*	16.7%
7	Тослог ургамлын дотоодын хангамж, дотоодын үйлдвэрийн хэрэгцээний хангалт	мян.тонн	-	48	21.3	79.8%
8		хувь	-	50	7.7	15.4%
9	Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж	тоо	131	5	139	100.0%
10	Отрын тусгай хэрэгцээний отрын бүс нутаг	сая.га	3	3.3	5.6	100.0%
11	Малчин өрхийн дундаж орлогын өсөлт	хувь	1,180,662 төг	10%	1,325,100*	100.0%
12	Мал эмнэлгийн үйлчилгээнд хамрагдсан малчин өрх	хувь	-	83.5	84.4	100.0%
13		бруцеллэз халдварлалт, хувиар	0.26%	0.02	0.19%	100.0%
14	Мал, амьтны зоонозын халдварт өвчний голомт тохиолдлын бууралт	Галзуу голомт, тохиолдлын бууралтын хувь	216 голомт, 284 тохиолдол	1.0	279 голомт, 360 тохиолдол	0.0%
15		Боомын голомт, тохиолдлын бууралтын хувь	6 голомт, 44 тохиолдол	1.0	12 голомт, 21 тохиолдол	25.0%
дундаж						56.7%

Тайлбар:

\*салбарын урьдчилсан гүйцэтгэлээр тооцсон,

- 2021 онд хүрэхээр төлөвлөсөн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй 2020 оны жилийн эцсийн үр дүнг харьцуулан үнэлж байгаа нь үнэлгээ буурах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

- Махны нөөц бүрдүүлсэн хэмжээ болон мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээ гэсэн 2 шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин нь Коронавируст халдвар /Covid-19/-г цар тахлын нөлөөнөөс шалтгаалж, төлөвлөсөн үр дүнд хүрээгүй тул хэрэгжилтийн үр дүн 0.0 хувиар дүгнэгдлээ.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ.

1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны нэгж, харьяа байгууллагуудын үнэлгээнд бодлогын баримт бичгийн үнэлгээг оруулан тооцдог болсноор журам, аргачлалд заасан хугацаанд тайлагнах болсон эерэг үр дүн гарч байна.

2. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний 2020 оны хэрэгжилтийн дундаж үнэлгээ 76.54 хувьтай байна. Энэ нь өнгөрсөн оны жилийн эцсийн дундаж үнэлгээтэй харьцуулахад 6.52 хувиар буурсан байна.

3. Хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээгээр:

- Санхүүжилтийн дутагдалтай байдлаас шалтгаалж хэрэгжилт хангагдаагүй 5 арга хэмжээ /төлөвлөгөөний 3.3.4.2.1, 3.3.4.6, 3.3.12.3, 3.3.13.3, 3.3.1.2 /,

- Удирдлага, зохион байгуулалтыг сайжруулах шаардлагатай 1 арга хэмжээ /төлөвлөгөөний 3.3.3.3 /,

- Уялдаа, хамтын ажиллагаа дутагдалтай байдлаас шалтгаалсан 4 арга хэмжээ /төлөвлөгөөний 3.3.4.2.2, 3.1.20.1, 3.3.12.3, 3.3.13.1/,

- Салбар дунд хэрэгжүүлэх бодлогын шийдлийг тодорхойлох шаардлагатай 3 арга хэмжээ /төлөвлөгөөний 3.1.20.1, 3.3.15.2, 5.1.12.2/,

- Ковид -19 цар тахлын эрсдэлээс шалтгаалан хэрэгжилт хангагдаагүй 3 арга хэмжээ /төлөвлөгөөний 3.3.3.2, 3.3.13.2, 3.3.13.3/ тус тус байна.

4. “Хүнсний сүлжээнд зохистой дадал, угтвар нөхцөл, удирдлагын тогтоолцооны стандартыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ”, “Хөдөө аж ахуй болон эрүүл ахуйн зохистой дадал”-ыг нэвтрүүлэх ажлуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

5. Үнэлэх боломжгүй 5 арга хэмжээний хувьд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хугацаа болоогүй байна.

## ТАВ. ЗӨВЛӨМЖ.

1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүрийг байгууллага, нэгж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусган төлөвлөхийг холбогдох нэгж, харьяа байгууллагад,

2. “Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих “Экспортын баталгааны сан” байгуулж ажиллуулна” /Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/, “Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана” /Бодлого төлөвлөлтийн газар, холбогдох бусад хэрэгжилтийн газрууд/ зэрэг салбар дундын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах чиглэлд холбогдох Төрийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, хэрэгжилт хангахыг,

3. “Хүнсний сүлжээнд зохистой дадал, угтвар нөхцөл, удирдлагын тогтолцооны стандартыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ”, “Хөдөө аж ахуй болон эрүүл ахуйн зохистой дадал” арга хэмжээний хэрэгжилт хангахыг Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт,

4. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөний

a. 3.3.4.2.1. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад ялган төвлөрүүлэх /Малын генетик нөөцийн хэлтэс/,

b. 3.3.4.6. Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачлага, хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжинэ /Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/,

c. 3.3.12.3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг Хөдөө аж ахуйн бирж, хоршооны бүтцэд тулгуурлан боловсронгуй болгож, Загвар хоршоодыг байгуулна /Жижиг дунд үйлдвэрийн газар, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/,

d. 3.3.13.3. Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" аяныг зохион байгуулах тогтолцоог сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ /Жижиг дунд үйлдвэрийн газар/,

e. 3.3.1.2. Баруун, зүүн бүсэд улаанбуудайн элеватор байгуулах замаар газар тариалангийн үр ашгийг сайжруулна /Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар/ арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийг төсвийн болон төсөл, хөтөлбөрийн эх үүсвэрээс шийдвэрлэж, хэрэгжилт хангахыг,

5. Сайдаас Аймгуудын Засаг дарга, ХХААГ-ын даргатай байгуулах гэрээнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан орон нутагт хэрэгжүүлэх арга хэмжээг орхигдуулахгүй тусгуулахыг холбогдох бүх нэгж, харьяа байгууллагын удирдлагад,

6. Цөм сүргийн үржлийн төвийн мал сүргийг чанаржуулах замаар стандартын шаардлага хангасан бог малын үржлийн өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулж, мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж, малчид, мал бүхий иргэдийг хангаж ажиллахыг Малын удмын сангийн үндэсний төвд тус тус зөвлөмжилж байна.

## ЗУРГАА. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ.

1. Төлөвлөгөөнд ижил нэрээр тусгагдсанаас тайлагналт давхардах зэрэг хүндрэл учруулж байгаа хэд хэдэн заалтыг шинэчлэн арга хэмжээний нэрээр төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байна. Үүнд:

3.3.4.2.1. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ гэснийг Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжийн хяналтад авах,

3.3.4.2.2. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ гэснийг Үүлдэр, омгийн малын цөм сүргийг бүрдүүлэх, үзлэг ангилалт хийх, ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах,

3.3.4.2.3. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ гэснийг Малын генийн санг хамгаалах, мал аж ахуйн үйлдвэрлэлд биотехнологийн ололт нэвтрүүлэх,

3.3.4.2.4. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ гэснийг Стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч өсгөн бойжуулах, малын чанар сайжруулах,

3.3.4.4.1. Уст цэг тогтоох хайгуул судалгаа, инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулна гэснийг Уст цэг тогтоох хайгуул судалгааны ажлыг хэрэгжүүлэх,

3.3.4.4.2. Уст цэг тогтоох хайгуул судалгаа, инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулна гэснийг Инженерийн хийцтэй худгийн хангамжийг нэмэгдүүлэх гэж тус тус нэршлийг өөрчлөх шаардлагатай байна. Ингэснээр тус арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинд өөрчлөлт орохгүй болно.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, /2020 оны жилийн эцэс/

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2020 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Нэгдсэн дүгнэлт	Үнэлгээ
<b>НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО</b>							
1	1.1.10. Засгийн газраас эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон зээл, санхүүжилтийн эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлүүлэх, хямдруулан худалдах, дампуурсан банкнуудын эрх хүлээн авагчдаас авах төрийн байгууллагуудын авлагыг Монголбанканд шилжүүлэх зэргээр Засгийн газрын санхүүгийн нөөцийг нэмэгдүүлнэ.	1. Засгийн газрын бондын хөрөнгөнөөс ЖДҮХС-д дамжуулан зээлдүүлсэн зээл, МУХС-гийн хөрөнгөөр бүрдүүлсэн улаан буудайн нөөцтэй холбоотойгоор улсын төсөвт төлөх өр төлбөрийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаас төлж барагдуулна.	2020 - 2024	ЖДҮХС-6,200.0 сая.төг, МУХС-2,500.0 сая.төг, ХААДС/МХС/-1,280.7 сая.төг		Засгийн газрын бондын хөрөнгөөр дамжуулан зээлийн хөрөнгийн санхүүжилтийн эргэн төлөлтөд СЯ-тай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаар 2020 онд ЖДҮХС-гаас 8,647.8 сая төгрөг төлөхөөс 6,200.0 сая төгрөг төлж гүйцэтгэл 72.1 хувь, Монгол улсыг хөгжүүлэх сангийн санхүүжилтийн эргэн төлөлтөд тус онд СЯ-тай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулаагүй бөгөөд тайлант онд ХААДС-гаас 11,053.8 сая төгрөг төлөхөөс 2,500.0 сая төгрөг төлж, гүйцэтгэл 22.6 хувьтай гарсан. Мөн Мал хамгаалах сангаар дамжуулан өвс, тэжээл авсан 40,000.0 сая төгрөгийн зээлээс 2020 онд 1,280.7 сая төгрөгийг төлж, уг зээлийн 66.8 хувь буюу 26,736.9 сая төгрөгийн зээлийг барагдуулсан байна.	70%
<b>ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>							
2	3.1.20. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих "Экспортын баталгааны сан" байгуулж ажиллуулна.	1. Бүтээгдэхүүнээ экспортод гаргасан аж ахуйн нэгжийг тусгайлан дэмжих "Экспортын баталгааны сан" байгуулж ажиллуулна.	2021 - 2024	-		Олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан Монгол Улсын ноос ноолуурын салбарын "Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт"-ыг явуулах эрх бүхий "Баталгаажуулалтын алба"-ыг байгуулсан. Монгол Улс ноолууран бүтээгдэхүүнээ "Монголын Хаан ширхэгт" чанарын тэмдгээр Говь ХК, Кашимер холдинг ХХК, Хан Богд ХХК бүтээгдэхүүний эрхээ баталгаажуулан экспортод гаргаж эхэлсэн.	50%
3	3.3.1. Атрын IV аяныг хэрэгжүүлж, тариалангийн тогтвортой үйлдвэрлэлийн хөгжлийг хангаж, бүтээгдэхүүнийг экспортлох, боловсруулах хүчин чадлыг нэмэгдүүлж, таримлын сэлгээ, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар салбарын бүтээмж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.	1. Газар тариалангийн үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг эрчимжүүлж, механикжилтын түвшинг нэмэгдүүлнэ	2021 - 2024			Засгийн газрын 138 дугаар тогтоолын дагуу 10.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 23 нэр төрлийн 277 ширхэг техник, тоног төхөөрөмжийг 263 иргэн, аж ахуйн нэгжид, 2.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 177 тонн ургамал хамгааллын бодис, 842 тонн нийлмэл бордоо, 72 тонн гумины бордооны үнийг тус тус 50 хувиар хөнгөлж нийтдээ 335 иргэн, аж ахуйн нэгжид 20-50 хүртэл хувийн урьдчилгаатайгаар тариалалтын өмнө зээлээр олгох ажлыг зохион байгуулав. Мөн БНХАУ-ын Засгийн хөрөнгөөр нийлүүлсэн төмс, хүнсний ногооны зориулалттай 50-80 морины хүчтэй дугуйт трактор, хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулсан техник тоног төхөөрөмжийн үнийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны 145 дугаар тушаалаар 50 хувиар бууруулж, ногоочдод	100%

					олгосон. нийт 500 гаруй техник тоног төхөөрөмж багтсан. Хүнсний ногооны механикжуулалтын түвшин ногооны төрлөөс хамаарч 45-60 хувьтай байна.	
4		2. Баруун, зүүн бүсэд улаанбуудайн элеватор байгуулах замаар газар тариалангийн үр ашгийг сайжруулна	2021 - 2024		Увс аймгийн Баруунтуруун, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд тус бүр 10.0 мянган тонн багтаамжтай үр тариа хадгалах элеваторын барилга байгууламжийн зураг төсөл, газрын асуудлыг 2020 онд бэлэн болгосон.	70%
5		3. Хөрсний үржил шимийг сайжруулах, нэгжийн ургацыг нэмэгдүүлэх зорилгоор бордоог хөнгөлөлттэй нөхцөлөөр олгоно	2021 - 2024		2020 онд “Тариалангийн талбайн хөрсний үржил шим, чийгийг нэмэгдүүлэх экологжсон арга, туршлага нэвтрүүлэх” зөвлөх үйлчилгээний ажлыг Ургамал, газар тариалангийн хүрээлэнгээр гүйцэтгүүлэв. Энэхүү ажлын хүрээнд хөрсний үржил шимийг сайжруулах ногоон бордуурт ашиглах 12 төрлийн таримал ургамлын харьцуулсан туршилт судалгааны ажлыг гүйцэтгэсний зэрэгцээ байгаль орчинд ээлтэй аргаар хөрсний чийг, агаар нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, хог ургамалтай тэмцэх технологийн зөвлөмж боловсруулсан. Энэхүү төслийн туршилтын талбайд "Хөрсний үржил шим, чийгийг нэмэгдүүлэх ногоон бордуур сэдэвт" үзүүлэх сургалт зохион байгуулж хөрс хамгаалах, газрын доройтлыг экологижсон аргаар сэргээх, биологийн олон янз байдлыг хамгаалахын ач холбогдолын талаар танилцуулга хийсэн. 2020 оны хаврын тариалалтад зориулан 523 аж ахуйн нэгж, иргэнд 322,2 тн ургамал хамгааллын бодис, 99 иргэн, аж ахуйн нэгжид 818,1 тн нийлмэл бордоо, 42,8 тн биологийн болон эрдэс бордоог үнийн дүнгээс 50 хувь хөнгөлж олгосон. 2021 онд тариалалтад шаардагдах бордооны тоо хэмжээ, нэр төрлийн талаар судалгаа хийж, шаардагдах бордооны тодорхой хэсгийг Хөдөө аж ахуйг дэмжих сангаар дамжуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр тариаланчдад олгох ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. ХААДС-гаас олгосон дэмжлэгийг хавсаргав.	90%
6		4. Энгийн болон инженерийн хийц бүхий услалтын системийг шинээр барьж, сэргээн засварлах замаар усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлнэ	2021 - 2024		“Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй” төслөөр хэрэгжих CS-14 буюу Охиндойн талын услалтын системийн биологийн төрөл зүйлийн мэргэжилтэн сонгон шалгаруулах тендер зарлаж зөвлөхийн баг сонгон шалгаруулж судалгааны ажлын эхлэлтийн тайланг Азийн хөгжлийн банк болон ХХААХҮЯ-ны ажлын хэсэг, төслийн багтай хамтран хэлэлцүүлж хүлээн авч АХБ-ны зөвшөөрлөөр 50 хувийн санхүүжилтийг хийлгээд байна. CS-15 буюу 12 услалтын системийн Байгаль орчны төлөв байдал болон нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөхийн тендерт "Green nature land" LLC түншлэл шалгарч гэрээг 11 сарын 15-нд байгуулан ажлыг эхлүүлээд эхлэлтийн тайлангийн хэлэлцүүлгийг цахимаар хийж санал өгсөн. Гэрээгээр 2021 оны 05 сарын 01-ний өдөр хүлээлгэж өгнө. CS-16 буюу	100%

					9 услалтын системийн инженерийн зураг төсөл зохиох тендерт "Hydro design project" LLC түншлэл шалгарч 11 сарын 01-ний өдөр гэрээ байгуулсан. гэрээгээр 30 хувийн гүйцэтгэлийн тайланг АХБ болон ХХААХҮЯ, төслийн нэгжтэй хамтарсан ажлын хэсэг хүлээн авч АХБ-д хүргүүлж зөвшөөрөл авсны үндсэн дээр санхүүжилтийг хийгээд байна. БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр олгож буй усалгааны тоног төхөөрөмж, хөдөө аж ахуйн техник тоног төхөөрөмжийг ХХААХҮ-ийн сайдын А-145, А-136 дугаар тушаалаар нийт үнийг 50 хувь хөнгөлж урьдчилгаа төлбөргүй жилийн 6 хувийн хүүтэй 6 жилийн хугацаатайгаар олгосон. Үүний үр дүнд зээлийн шалгуур хангасан үр тариа, тэжээлийн таримлын тариалан эрхэлдэг 30 аж ахуйн нэгж, иргэнд 42 ширхэг бороожуулагчийг зээлээр олгож 3041 га талбайг усжуулах боломж бүрдсэн.	
7		5. Өвөл, зуны хүлэмжийн цогцолбор аж ахуйнууд байгуулж дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, импортыг бууруулна	2021 - 2024		ЖДҮ-ийг хөгжүүлэх сангаас 2020 онд Говь-Алтай, Орхон, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймаг Улаанбаатар хотын 19 аж ахуйн нэгжид хүлэмжийн аж ахуйг байгуулахад зориулан 1,886.0 сая төгрөгийн хөнгөлттэй зээл олгоод байна. Улсын төсвийн 74.2 сая төгрөгийн санхүүжилтээр 32 м <sup>2</sup> талбай бүхий 45 иж бүрдэл нийлэг хальсан зуны хүлэмж нийлүүлж хүлэмжийн талбайг 1440 м <sup>2</sup> талбайгаар нэмэгдүүлэв. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй "Хоршоолсон хэлбэрээр хүнсний ногооны аж ахуйг хөгжүүлэх" төслийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө суманд 228 сая төгрөгийн өртгөөр 500 м <sup>2</sup> өвлийн хүлэмжийг байгуулж байна. Тус төслийн хүрээнд 345.5 сая төгрөгийн санхүүжилтээр 32 м <sup>2</sup> талбай бүхий 110 иж бүрдэл, 120 м <sup>2</sup> талбай бүхий 50 иж бүрдэл нийт 9520 м <sup>2</sup> талбай бүхий зуны хүлэмж нийлүүлж Сэлэнгэ, Төв, Дархан-Уул, Увс аймгийн ногоочдод олгов. Улаанбаатар хотын иргэдийн хүнс, тэжээлийн аюулгүй байдлыг хангах зорилгоор "Ухаалаг хүлэмжийн аж ахуй, нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх" төслийг 2021 оноос хэрэгжүүлэхээр Солонгосын хөдөөгийн хөгжлийн эдийн засгийн хүрээлэнтэй хамтран боловсруулж БНСУ-ын талд санал хүргүүлсэн ба урьдчилсан байдлаар 7.0 сая ам долларын төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдээд байна. Мөн АНУ-аас Монгол улсад хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхэд зориулан 3.0 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр шийдвэрлээд байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотод 4 аж ахуйн нэгж 6.4 тэрбум төгрөгөөр 11200 м <sup>2</sup> , Төв аймагт 3 аж ахуйн нэгж 1.0 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 2400 м <sup>2</sup> хүлэмж байгуулав. Эдгээр арга хэмжээний үр дүнд хүлэмжийн талбай 30000 м <sup>2</sup> -аар, хүлэмжийн ногооны үйлдвэрлэл 700 тонноор нэмэгдэх боломж бүрдэж байна.	90%

8		6. Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлж, үрийн чанар, хангамжийг сайжруулна	2021 - 2024		Улсын төсвийн 90.0 сая төгрөгийн хөрөнгөөр бүс нутгийн хөрс, цаг уурын онцлогт тохирсон таримал ургамлын шинэ сортыг сорих, шалгаруулах зорилгоор тариалангийн төв, баруун, зүүн, хангайн бүсэд тус бүр улаанбуудайн 11 сорт, төвийн бүсэд төмсний 6 сорт сорих ажлыг Ургамал, газар тариалангийн хүрээлэнтэй гэрээ байгуулан гүйцэтгүүлэв. Гэрээт ажлын хүрээнд тариалангийн 4 бүсийн 6 байршилд улаанбуудайн 11 шинэ сорт, төвийн бүсийн 2 байршилд төмсний 6 шинэ сортыг үйлдвэрлэлийн нөхцөлд сорьсоны зэрэгцээ, сорт сорилтын талбайд эрдэмтэн, судлаач, тариаланчдын төлөөллийг оролцуулсан үзүүлэх сургалт зохион байгуулав. Мөн дээрх ажлыг хүрээнд Төв аймгийн Борнуур сумын сорт сорилтын салбарт төмсний 4 сортыг сорьсоны зэрэгцээ Хөвсгөл аймгийн Тариалан суманд сорт сорилтын 50 га талбайд уринш боловсруулалт хийж салбаруудын үйл ажиллагааг эхлүүллээ. Улаанбуудайн үрийн анхдагч аж ахуйг хөгжүүлэх төслийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын зөвлөлд танилцуулсан. Таримлын үрийн аж ахуйг хөгжүүлэх, чанар, хангамжийг сайжруулах зорилгоор “Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулаад байна. Шинээр боловсруулсан урамшуулал олгох журмын төсөлд Үр үржүүлэгчдийн үржүүлж борлуулсан улаанбуудайн элит үр, нэгдүгээр үржүүлгийн үрэнд урамшуулал олгохоор тусгасан. Улаанбуудайн супер элит үр үржүүлэхэд дэмжлэг үзүүлэх, элит үрийн нөөц бүрдүүлэх ажлыг 200.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.	70%
9		7. Тариалангийн талбайн хог ургамал, хортон шавж, ургамлын өвчин, мэрэгч гэх мэт хөнөөлт организмын тархалтын судалгаа хийх, Ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021 - 2024		2020 онд “Баруун бүсийн Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгийн тариалангийн талбайн хөнөөлт организмын тархалт, зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох, судалгаа хийх, тэмцэх арга хэмээг боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажлыг гүйцэтгүүлэхээр Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй гэрээ байгуулсан. Тус хүрээлэнгээс дээрх аймгуудын тариалангийн талбайн хөнөөлт организмын тархалтын судалгааг хийж, аймаг тус бүрийн судалгааны тайлан, хөнөөлт организмыг таних катологи, зөвлөмжийг ирүүлсэн. Судалгааны үеэр Ховд, Говь-Алтай аймагт тариалангийн талбайн зарим хэсэгт манай улсад гадаад хорио цээртэй хог ургамал, Увс, Завхан, Баян-Өлгий аймгийн тариалангийн талбайн зарим хэсэгт дотоод хорио цээртэй болон гоц хөнөөлт организм тархсаныг тогтоосон. ХХААХҮЯ-ны Газар тариалангийн чиглэлээр бараа, ажил, үйлчилгээ хүлээн авах ажлын хэсэг ажлыг хүлээн авч, тайлан, зөвлөмж, хэрэгжүүлэх арга хэмжээний тухай саналыг дээрх аймгуудад хүргүүлээд байна. Ургамал хамгааллын тухай хуульд заасны дагуу 2021 онд төвийн бүсийн аймгуудын тариалангийн талбайн тархалтын	70%



					судалгааг хийх ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна. Монгол-Германы Тогтвортой хөдөө аж ахуй төслийн багтай хамтран Завхан аймгийн Улиастай хотод 2020 оны 7 сарын 22-24-ний өдрүүдэд Ховд, Говь-Алтай, Завхан, Увс аймгийн төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 60 гаруй тариаланчид зориулан "Газар тариалангийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх" сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтаар хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуйд зохистой дадал, ургамал хамгааллын цогц арга хэмжээг нэвтрүүлэх, бордоо, ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээний талаар Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэмтэд сургалт хийсэн ба тус яамнаас газар тариалангийн салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль эрх зүй, бодлогын талаар илтгэл тавьж оролцсон.	
10		8. Газар тариалангийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлнэ	2021 - 2024		Швейцарын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлж буй Монгол ногоо төслийн багтай хамтран "Жимс, жимсгэнэ, хүнсний ногооны үйлдвэрлэлд ХААЗД-ын хялбаршуулсан заавар нэвтрүүлэх, Ургамал хамгааллын цогц арга хэмжээ" сэдэвт төрийн албан хаагчдыг чадавхжуулах цахим сургалт, Монгол-Германы Тогтвортой хөдөө аж ахуй төслийн багтай хамтран Завхан аймгийн Улиастай хотод 2020 оны 7 сарын 22-24-ний өдрүүдэд Ховд, Говь-Алтай, Завхан, Увс аймгийн төмс, хүнсний ногоо, хүлэмжийн аж ахуй эрхлэгч 60 гаруй тариаланчид зориулан "Газар тариалангийн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх" сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан. Сургалтаар хөрсний үржил шимийг сайжруулах, элэгдэл эвдрэлээс хамгаалах, эрдэс ба органик бордоо бэлтгэх, бордоо ургамал хамгааллын бодисын зохистой хэрэглээний талаар аймаг орон нутгийн хөдөө аж ахуй, газар тариалан хариуцсан мэргэжилтнүүдэд зориулан мэргэжлийн байгууллага, эрдэмтэн багш нараар илтгэл тавиулах, хичээл заах үйл ажиллагааг зохион байгуулсан.	50%
11		9. Чацарганы өрсөлдөх чадварыг сайжруулан экспортыг нэмэгдүүлэх, бусад жимс, жимсгэний таримал, сортуудыг турших, нутагшуулах, тариалах арга технологи боловсруулах, суулгац үржүүлгийн газруудыг орон нутагт байгуулна	2021 - 2024		ЖДҮХөгжүүлэх сангаас 2020 онд 9 аймаг, нийслэлийн 14 аж ахуйн нэгжийн хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулах үйлдвэрийн төсөлд 1,428.0 сая төгрөгийн зээл олгож бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэв. Европын холбооны ТРАМ төслийн хүрээнд "Монгол чацаргана дэлхийн зах зээлд" олон улсын форум зохион байгуулж гадаад зах зээлд гаргахад тулгарч буй асуудал, шийдвэрлэх арга зам, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр илтгэл, хэлэлцүүлэг хийв. АХБ-ны хэрэгжүүлж буй "Хөдөө аж ахуйн нэмүү өртгийн сүлжээг дэмжих" техник туслалцааны төслийн "Чацаргана" бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд БНХАУ-д үйлдвэрлэсэн шавьж баригч наалтын цехийг Ургамал хамгааллын хүрээлэнд суурилуулсны дагуу 2020 онд 84.47 сая төгрөгийн 5 тонн түүхий эд, материал худалдан авч, эхний бүтээгдэхүүнийг 9 сард үйлдвэрлэж	70%

					туршилт судалгааг хийж, органик тариалан хөгжүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах нөхцөл бүрдүүлэв. Мөн төслийн хүрээнд ШУТИС-ын Техник, технологи туршилт судалгааны төвд 2019 онд чацарганы үрийн тосыг CO <sup>2</sup> -ийн хийгээр ялгааг орчин үеийн тоног төхөөрөмжийг суурилуулсан ба 2020 онд Хаан жимс ХХК, Хархорин ХК, Тэсо корпораци туршилтаар үрийн тосоо ялган, гадаад орнуудад экспортлох судалгаа хийлгэж, хамтран ажиллаж байна. Улсын төсвийн санхүүжилтээр Говь-Алтай, Сүхбаатар аймагт суулгац үржүүлгийн төв байгуулах тендер шалгаруулалт зохион байгуулж нийт 99.0 сая төгрөгийн гэрээ байгуулан тус бүр 3 га талбай бүхий суулгац үржүүлгийн төвийг байгуулж орон нутагт нутагшсан стандартын шаардлага хангасан суулгац үржүүлэх боломж бүрдэв. АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй “Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслийн 15.0 мянган ам.долларын санхүүжилтээр ХААИС-ийн харьяа Борнуур дахь судалгааны төвд “Жимс жимсгэний сортуудын туршилт судалгаа хийх, жимс жимсгэний генефонд байгуулах” гэрээ байгуулж чацарганы 20000 гаруй ширхэг ногоон мөчир, 200 ширхэг интоор, 20 ширхэг алим, 122 ширхэг чавганы суулгацыг үржүүлгийн талбайд тариалав.	
12		10. Тариалангийн талбайн хөрсний үржил шим, төлөв байдлын мониторинг хийх, хөрсний үржил шимийг нэмэгдүүлнэ	2021 - 2025		“Тариалангийн хөрсний мониторингийн сүлжээ байгуулах, тариалангийн хөрсний мониторингийн сүлжээний байршлын болон агрохимийн картограммын зураглал хийх” зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт зарлаж, ХААИС-ийн Агроэкологийн сургуультай 2020 оны 06 сарын 16-ны өдөр гэрээ байгуулсан. Энэхүү ажлын үр дүнгээр төв, зүүн, говийн бүсийн тариалангийн талбайд хөрсний үржил шимийг тодорхойлох 150 цэг байгуулан цэг тус бүрээс хөрсний дээж авч шинжилгээнд хамруулан хөрсний картограммын зураглалыг үйлдсэн. Мөн дээрх цэгүүдийн хөрсний шинжилгээний үр дүнгийн мэдээллийг багтаасан monsoil.mn цахим хуудсыг боловсруулсан. 2021 онд цэгийн тоог нэмэгдүүлж, жил бүр шинжилгээнд хамруулан үр дүнг харьцуулан хөрсний үржил шимийг хянах боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.	90%
13	3.3.2. Газар тариалан, хөдөө аж ахуйн төв Дархан, Сэлэнгэ бүс нутагт агротехникийн засвар үйлчилгээний төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ.	1. Сэлэнгэ аймгийн Сант суман дахь Хөдөө аж ахуйн сургалт үйлдвэрлэлийн баазыг өргөтгөн хөгжүүлж, газар тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх малчид, тариаланчдыг сургах, давтан сургах, залуу тариаланч, малчдыг бэлтгэх "Илгээлтийн эзэн"-аяныг өрнүүлнэ	2021 - 2024		Сэлэнгэ аймгийн Сант суман дахь Хөдөө аж ахуйн сургалт үйлдвэрлэлийн баазыг өргөтгөн хөгжүүлж, газар тариалангийн бүсэд эрчимжсэн мал аж ахуй эрхлэх малчид, тариаланчдыг сургах, давтан сургах, залуу тариаланч, малчдыг бэлтгэх "Илгээлтийн эзэн" аяныг өрнүүлэх талаар Монгол Германы хамтарсан Хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил төсөл болон Германы Хөдөө аж ахуйн яаманд уламжлан хамтран ажиллах саналыг хүргүүлсэн. ХААИС-ийн Инженерийн сургуультай хамтран ажиллаж байна.	30%

14		1. Махны нөөц бүрдүүлнэ	2021 - 2024	5.900,0	Нийслэлийн хүн амын 2020-2021 оны өвөл, хаврын улирлын махны хэрэгцээнд зориулан арилжааны банкны шаардлага хангасан 16 аж ахуйн нэгжтэй "Мал, мах бэлтгэх, махны нөөц бүрдүүлэх, түүнийг хадгалах, худалдан борлуулахад хяналт тавих гэрээ" байгуулсан. Гэрээгээр дээрх аж ахуйн нэгжүүд нийт 13 мянган тн мах бэлтгэж, нөөцлөхөөс 2021 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар 8.0 мянган тн мах бэлтгэж, нөөцөлсөн байна. Махны нөөц бүрдүүлэлтийн явц 70 хувьтай байна. 28 аж ахуйн нэгжийн 21.2 мянган тонн бэлтгэсэн нөөцийн махны хүүгийн хөнгөлөлтөд 2020 онд 5,9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож ажилласан.	70%
15	3.3.3. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангаж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	2. Мах, махан бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ	2021 - 2024		"Алсын хараа-2050" урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт, бичгүүдэд Монгол улсын эдийн засгийн тулгуур салбарын нэгээр ХАА-н салбарыг тодорхойлж хүнс экспортлогч орон болох тэр дундаа мах, махан бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэхээр тусгагдсан. Дорноговь аймагт Covid-19 вирусын өвчлөл бүртгэгдсэн 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс импортлогч БНХАУ-ын тал махны импортоо зогсоож, экспортлогч аж ахуйн нэгжүүдийн мах ачсан тээврийн хэрэгсэл Замын-Үүд боомтод хил гарч чадахгүй, хүндрэлтэй нөхцөлд орсон. ГХЯ, Монгол Улсаас БНХАУ-д суугаа ЭСЯ-тай хамтран хүнсний хангамж, аюулгүй байдал, хүнсний тээвэрлэлтийг зохион байгуулах, Нэг цонхны бодлогоор шийдвэрлэх талаар импортлогч БНХАУ-ын талтай тохиролцсоноор махны экспортыг эхлүүлсэн. Тус яамны зүгээс вирусын дэгдэлттэй холбоотой мах махан бүтээгдэхүүний экспортын үйл ажиллагааг түргэн шуурхай явуулах боломжийг эрэлхийлэх, нөгөө талаас экспортлогч аж ахуйн нэгжүүдэд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор экспортод гарч байгаа бүтээгдэхүүн вирус дамжих эрсдэлгүй болохыг баталгаажуулж нуклейн хүчлийн шинжилгээ хийхээр шийдвэрлэн, холбогдох хяналтын байгууллагууд хяналт тавин ажиллаж байна. 2020 онд 38,6 мянган тонн мах экспортолсон гаалийн гүйцэтгэлтэй байна. ХАБҮЗ-өөс 2020 онд махны экспортыг нэмэгдүүлэх зорилгоор 40 мянган тонн дулааны аргаар боловсруулсан мах, 15 мянган тонн адууны мах нэмэлтээр экспортлох тоо хэмжээг тогтоон, аж ахуйн нэгжүүдэд хуваарилсан. 2021 оны эхний хагас жилд багтаан экспортлох нөхцөлийг бүрдүүлж, мөн олгосон тоо хэмжээ 12 сар хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байх, экспортлогч аж ахуйн нэгжүүдийг дэмжих зорилгоор 2019 оны 329 дүгээр тогтоолоор батлагдсан "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ын нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн	70%

					4 дүгээр тогтоолоор батлуулсан. /Гадаад харилцааны чиглэлээр хийсэн ажлыг хавсаргав/	
16		3. Хүнсний сүлжээнд зохистой дадал, угтвар нөхцөл, удирдлагын тогтолцооны стандартыг хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	2021 - 2024		Хүнсний боловсруулах салбарт Үйлдвэрлэлийн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг эцэслэн боловсруулж, ХХААХҮ-ийн болон ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар бэлэн болгосон. Тус зааврын төслийг салбарын хууль тогтоомж, холбогдох журмуудтай хянан үзэж байна. - Хүнсний худалдааны газарт эрүүл ахуйн зохистой дадлын стандартын төслийг боловсруулах хүрээнд олон улсын болон гадаад орны стандарт баримт бичиг, дүрэм, журам, үндэсний стандартын үзүүлэлт, шаардлагыг судалж, Хүнсний худалдаанд мөрдөх эрүүл ахуйн зохистой дадлын стандартын хамрах хүрээ, тавигдах шаардлагыг хүнсний сүлжээний худалдааны үе шатанд удирдлагын оновчтой тогтолцоо бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх зорилтын хүрээнд стандартын агуулга, бүтцийг тогтоосон. Хүнсний худалдааны газарт мөрдөх эрүүл ахуйн зохистой дадлын стандартын төслийг Европын Холбоонд мөрдөж байгаа зохистой дадлын арга зүйн баримт бичигт үндэслэн боловсруулсан. - "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зохистой дадлын хялбаршуулан нэвтрүүлэх заавар"-ын төслийг олон улсад баримтлаж буй эрхзүйн баримт бичиг, гарын авлагыг орчуулан харьцуулалт хийн боловсруулж, холбогдох байгуулагаас санал авч, яамны цахим хуудсанд байршуулан хэлэлцүүлж байна.	70%
17		4. Мал амьтан, ургамлын гаралтай органик хүнсийг баталгаажуулан, худалдааны түнш орнуудад хүлээн зөвшөөрүүлнэ	2021 - 2024		1. Дэлхийн банкны 2020-2023 онд хэрэгжих Экспортыг дэмжих төслийн Бүрэлдэхүүн хэсэг 3-т “Баталгаажуулалтын үйлчилгээ, чанарын удирдлагыг сайжруулах” асуудлыг тусгасан. Үүнд: а. аж ахуйн нэгжийн бараа бүтээгдэхүүнийг олон улсын болон импортлогч орны чанар, стандартын шалгуурыг хангахад дэмжлэг үзүүлэх, б. дотоодын тохирлын үнэлгээ, баталгаажилтын байгууллагын чадавх, хамрах хүрээ, хүчин чадлыг олон улсын түвшинд дүйцүүлэх, в. Үндэсний итгэмжлэлийн байгууллагыг чадавхжуулах зэрэг болно. Төслийн хүрээнд мал аж ахуйн органик үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр 2021 онд хамтран ажиллах чиглэлийг боловсруулж, төслийн баг болон яамны холбогдох албан тушаалтанд хүргүүлэв. г. Монгол Улсын хөдөө аж ахуйн салбарын нэмүү өртгийн сүлжээний мастер төлөвлөгөө боловсруулах төсөл" 2. MONMAP-AVC-ийн зөгийн балны туршилтын төслийн хүрээнд органик зөгийн аж ахуйн бүтээгдэхүүнийг баталгаажуулах, БНХАУ руу экспортлох чиглэлээр хамтран ажиллах саналыг төслийн багт хүргүүлж, цахим хурал зохион байгуулав. 3. Органик бордоо үйлдвэрлэх цахим сургалтын модуль боловсруулж, зохион байгуулах санхүүжилтийн саналыг боловсруулж, хүргүүлэв.	70%

					<p>4. "Монтаримал" ХХК-ийн Баянчандмань сумын Шарын аманд байрлах үхрийн фермийн үйл ажиллагааг шилжилтийн үеийн органик үйлдвэрлэлд шилжүүлэх, сүү, сүүн бүтээгдэхүүнийг баталгаажуулах эхний ажлууд хийгдэж байна.</p> <p>5. БНСУ руу сүү, сүүн бүтээгдэхүүн экспортлох хүсэлтийг мал эмнэлгийн эрүүл ахуйн гэрчилгээний загварын хамт боловсруулж хүргүүлэв.</p> <p>6. БНХАУ руу экспортлох хөх тариа, улаан буудайн гурилын Протоколыг албажуулж, экспортын эрх зүйн орчныг бий болгов.</p> <p>7. БНХАУ руу экспортлох зөгийн бал, сүү, сүүн, малын дайвар түүхий эд бүтээгдэхүүний холбогдох экспортын баримт, бичгийг тохирох чиглэлээр ажиллаж 5 удаа хорио цээрийн асуумжийн хариуг боловсруулж Хятадын талд хүргүүлэв.</p> <p>8. Япон Улс руу сүү сүүн бүтээгдэхүүн экспортлох боломжийг бий болгох зорилгоор хяналтын асуумжийн хариуг боловсруулан хүргүүлэв.</p>	
18		<p>7. Тослог ургамлын үрийн нөөц бүрдүүлэх, тосны үйлдвэрийн түүхий эдийн чанар, хангамжийг сайжруулна</p>	2021 - 2024		<p>1. Сэлгээний таримлын тариалалтыг нэмэгдүүлэх, үрийн нөөц бүрдүүлэх тухай” асуудлаар Сайдын зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаанд танилцуулга хийж, 02 тоот зөвлөмж гаргуулан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллав. Энэ хаврын тариалалтад шаардлагатай тосны ургамал болох Рапсын хар үр 350 тонныг импортоор нийлүүлэх ажлыг технологийн хугацаанд багтаан шуурхай зохион байгуулж, хамтран ажиллах тухай үүргийг ХААДС-д хүргүүлж хэрэгжилтийг зохион байгуулан ажилласнаар тосны ургамлын үр 150 тонныг нийлүүлэхээр "Майнд тэйч" ХХК-тай гэрээ байгуулж, дамжуулан зээлдүүлэх аргаар нийлүүлэх ажлыг зохион байгуулснаар нийтдээ 61.0 мянган га-д тосны ургамал тариалж, ургац хураалтын дүнгээр 21.3 мянган тонн тосны ургамал хураан авсан дүнтэй байна. "Майнд тэйч" ХХК-ийн ургамлын тос шахах, боловсруулах, савлах иж бүрэн үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах, түүхий эдийн зохих нөөц бүрдүүлэх зорилгоор рапсын үрийн экспортод зөвшөөрөл олгохгүй байх хүсэлтийг МХЕГ-т хүргүүлж хамтран ажиллаж байна.</p> <p>2. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлуулсан. Хуульд ургамлын тосны хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортлоход гаалийн албан татвараас чөлөөлүүлсэн.</p> <p>3. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр батлуулсан. Тус хуульд ургамлын тосны хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортлоход, түүнчлэн Монгол</p>	70%

					Улсын нутаг дэвсгэрт боловсруулсан ургамлын тосны нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлүүлсэн. 4. Дээрх 2 хуулийн хэрэгжилтийг хангаж ургамлын тосны хангамж, үнийг тогтвортой байлгах зорилгоор тослог ургамал, ургамлын түүхий тос импортлогч аж ахуйн нэгжтэй Бодлогын гэрээ байгуулан ажиллаж байна.	
19	3.3.4. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	1. Малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулна	2021 - 2024	0	Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг шинээр байгуулах, үүсгэл санаачилгыг дэмжих чиглэлийг бүх шатны мэргэжлийн байгууллагад хүргүүлж ажилласнаар 2020 онд 18 нэгж шинээр байгуулагдаж, улсын хэмжээнд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нийт 139 нэгж 21 аймаг, нийслэлийн 115 сум, 2 дүүрэгт тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийг дэмжих зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр хийгдэж буй үзлэг, ангилалтын ажлыг гэрээгээр гүйцэтгүүлэх, нэгжийн мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах, багаж тоног төхөөрөмжөөр үе шаттай хангах ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. 2020 онд улсын төсвийн 430.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн малын үзлэг ангилалтын ажлыг 59 мал үржүүлэг технологийн нэгжтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлэв.	90%
20	3.3.4. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой байдлыг хангах, малын чанар, ашиг шимийг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, эрчимжсэн мал аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж, "Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2.1. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ	2021 - 2024	0	Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх ажлыг 21 аймаг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан бөгөөд 2020 оны эцсийн байдлаар нийт 202,0 мянган хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлснээс Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний 77 нэгжид 9,7 мянган хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлээд байна. Хуц, ухныг мэргэжлийн нэгжид ялган төвлөрүүлснээр тухайн бүс нутгийн онцлогт тохирсон, үржүүлэхийг зөвшөөрсөн, удам гарваль, ашиг шимийн чиглэл тодорхой, үржлийн бүртгэл бүхий хээлтүүлэгчээр малчид, мал аж ахуй эрхлэгчдийг хангаж, малын чанар сайжрах боломж бүрдэж байгаа болно. Сайжруулагч малыг үржилд тохируулан сонгох, цөм сүрэг бүрдүүлэх технологийн журмын төслийг боловсруулж, орон нутгийн мэргэжлийн байгууллага, салбарын сургалт, эрдэм шинжилгээний байгууллага, мэргэжлийн холбоодоос санал авч, ХХААХҮЯ-ны цахим хуудсанд олон нийтэд нээлттэй байршуулж ажиллав. Төслийг таван төрлийн малын үүлдэр, ашиг шимийн орон тооны бус зөвлөл, МГНҮЗХорооны ээлжит бус хурлаар хэлэлцүүлэн, бүх шатны хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган боловсруулж, ХХААХҮЯ-ийн сайдын 2020 оны А-336 дугаар тушаалаар баталгаажуулан, ХЗДХЯ-нд хүргүүлснээр хууль эрх зүйн нэгдсэн сангийн УБД4892 бүртгэгдэн баталгаажив. Журмыг бүх шатны мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн.	50%

21		2.2. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ	2021 - 2024	0	<p>Монгол Улсад баталгаажсан 52 үүлдэр, омгийн малын цөм сүргийг бүрдүүлэх, үзлэг ангилалт хийж ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж, технологит хугацаанд нийт 12.9 мянган малчин өрхийн цөм сүрэгт бүртгэгдсэн 325.4 мянган малыг шинээр ялган тэмдэглэж, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд /оффлайн, онлайн/ 1.555.2 сая малын мэдээллийг орууллаа. Мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн 1.5 сая малын 1.1 хувь 17.4 мянга нь үржлийн хээлтүүлэгч байна. "Монгол улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх" /STDF/PG/534/ туршилтын төслийн хүрээнд Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программын туршилтыг Өвөрхангай аймгийн ХХААГ, сумдын ХААТ, МҮТН, төсөлд сонгогдсон Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга сумын малчдыг хамруулан зохион байгуулж, 173.2 мянган мал бүртгэлжүүлэх, Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд мэдээллийг оруулах туршилтыг амжилттай зохион байгуулав. - Монгол адууны үүлдэрлэг байдалд молекул биологийн судалгаа хийх, стандартыг шинэчлэн тогтоох, хурдан морины цахим бүртгэлийн программ, мэдээллийн сан бий болгох ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулж, 1200 адуунд туршилтын чип суулгах, цус авах ажлыг гүйцэтгэв. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд улс болон орон нутгийн төсөв, төслийн санхүүжүүлж ялган тэмдэглэсэн малын мэдээллийг бүрэн оруулав.</p>	70%
22		2.3. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ	2021 - 2024		<p>2020 онд гойд ашиг шимтэй махны чиглэлийн Сэлэнгэ, Герефорд, Сүүний чиглэлийн Швейцын бор, Хар тарлан үүлдрийн бухаас 5500 тун үр, тоо толгой цөөрч доройтож мөхөх, устахаас хамгаалах зорилгоор Баянхонгорын Бөмбөгөрийн улаан, Увс аймгийн Баяд үүлдэр, Сартуул үүлдрийн хуцаас 4800 тун үр, гойд ашиг шимт Суффолк, Романов, Брекшон, Дүйчер, Меринос үүлдрийн хуцаас 2500 тун үр, нийт 12800 тун үр үйлдвэрлэн малын генийн санд баяжилт хийв. Нийслэл, орон нутагт ажиллаж байгаа мал үржүүлгийн 32 техникчтэй гэрээ байгуулан иргэд, аж ахуйн нэгж, иргэдийн нийт 6953 үнэнд сүүний чиглэлийн өндөр ашиг шимтэй бухны үрээр, Зарим аймаг, иргэд, аж ахуйн нэгжээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Дорноговь аймгийн Мандах, Төв аймгийн Баян-Өнжүүл, Өмнөговь аймгийн Гурвантэс, Хэнтий аймгийн Биндэр, Баянхутаг, Жаргалтхаан, Архангай аймгийн Хотонт, Говьсүмбэр аймгийн Сүмбэр, Сүхбаатар аймгийн Сүхбаатар, Төв аймгийн Сэргэлэн сумын нийт 10 аж ахуйн нэгж, малчдын нийт 2337 толгой эм хонинд гойд ашиг шимт Суффолк, Эделбайв, Допер үүлдрийн хуц болон Барга үүлдрийн хуцны үрээр, нийт 9290 малд зохиомол хээлтүүлгийн ажлыг 85,6-90,0 хувийн үр дүнтэй хийж гүйцэтгэв. Бод, бог малын зохиомол хээлтүүлгийн үржүүлгийн техникч бэлтгэх сургалтыг 2 удаа зохион байгуулан</p>	90%

					Архангай, Өвөрхангай, Өмнөговь, Дундговь, Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Төв аймгийн 16 сумын 20 мал зүйч, 10 малын эмч, 10 фермер эрхлэгч, нийт 40 гаруй мэргэжилтнийг хамруулан мэргэжлийн чадамж олгож иж бүрэн багаж төхөөрөмжөөр хангаж ажиллав. Дорнод, Өвөрхангай, Дархан - Уул, Сэлэнгэ, Орхон, Архангай, Хэнтий, Төв, Завхан аймгийн 24 сум, дүүрэгт байгаа гэрээт 32 мал үржүүлгийн техникчийн захиалгын дагуу стандартын шаардлага хангасан Хосолмол ашиг шимт бухны 4231, сүүний чиглэлийн бухны 1007, махны чиглэлийн бухны 1182, хуц, ухны 1150 тун, нийт 7570 тун гүн хөлдөөсөн үрийг хөнгөлттэй үнээр генийн сангаас олгов. Шингэн азотын үйлдвэрт нийт 3571 л азот үйлдвэрлэж, генийн санд 2375,5 л, үр үйлдвэрлэлд 670 л, гэрээт техникч нарт 251,5 л олгов.	
23		2.4. Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ	2021 - 2024	0	Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилт хангуулах ажлын хүрээнд аймаг, суманд Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж байгуулах, нэгжээр дамжуулан чанар стандартын шаардлага хангасан үржлийн малыг бойжуулж борлуулах, улмаар малын чанарыг сайжруулах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэв. Төрийн болон орон нутгийн өмчит цөм сүргийн үржлийн аж ахуйд өсвөр хээлтүүлэгч сонгон тавих, үржилд худалдан борлуулах ажлыг хэрэгжүүлж, 241 хээлтүүлэгчийг худалдан борлуулж, 297 өсвөр хээлтүүлэгчийг үржилд сонгон тавиад байна.	ҮБ-гүй
24		3. Орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц бэлчээрийг шинээр бий болгох, хил заагийг баталгаажуулах, ашиглалт хамгаалалтыг сайжруулна	2021 - 2024		Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын захиргаа Засгийн газрын 2007 оны 187 дугаар тогтоолоор батлагдсан “Аймаг дундын отрын бэлчээр ашиглалтын нийтлэг журам”-ын дагуу улсын тусгай хэрэгцээний аймаг дундын 9 отрын бүс нутгийг ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллаа. 2020 онд аймаг дундын Чойбалсан, Хөх дэл отрын бүс нутагт 2021-2023 онд хэрэгжүүлэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулав. Отрын бүс нутгуудад 2019-2020 оны өвөл отроор өвөлжиж, хаваржсан малчдыг 04 дүгээр сарын 1-ний өдрийн дотор чөлөөлөв. Отрын бэлчээрийн ашиглалтыг зохицуулах үүрэг бүхий орон тооны бүс зөвлөлийн хурлыг 09, 10 дугаар сард аймаг дундын отрын бүс нутгуудад зохион байгуулж, цаг уур орчны шинжилгээний газраас гаргасан бэлчээрийн даацад тохирсон 680.000 толгой малыг отроор өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулав. Засгийн газрын 138 дугаар тогтоолоор аймаг дундын 7 отрын бүсэд өвөлжиж, хаваржиж буй малчдад зориулсан аюулгүй нөөцийн ногоон тэжээл 612.5 тн, хивэг 350 тн хивэг худалдан авах 406.0 сая төгрөг шийдвэрлүүлэв. Аюулгүй нөөцийн ногоон тэжээл, хивэг худалдан авах тендер сонгон шалгаруулалт зохион байгуулав. Архангай, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Ховд, Хөвсгөл аймагт орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бүс нутгийн бэлчээрийн судалгаа хийх, бэлчээрийн	90%



					хэв шинжийг тодорхойлох, отрын бэлчээрийн хилийн заагийг баталгаажуулж газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд оруулах, тухайн орон нутгийн тусгай хэрэгцээний сум дундын отрын бэлчээр ашиглалтын талаар авах арга хэмжээний санал боловсруулах ажлын хэсгийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-153 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Энэ хүрээнд ХХААХҮЯ, АДОБАЗ, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар, ШХА-ийн Ногоон алт малын эрүүл мэнд төсөл, Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбооны төлөөлөл бүхий ажлын хэсэг дээрх газар дээр нь очиж аймаг, сумдын удирдлагатай уулзалт зохион байгуулсан.	
25		4.1. Уст цэг тогтоох хайгуул судалгаа, инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулна	2021 - 2024		2020 онд Улсын төсвийн 250.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Завхан, Увс, Төв, Хөвсгөл аймгийн 200 цэгт “Энхсүлд” ХХК, “Ус-Амьдрал” ХХК, “Монкаротаж” ХХК, “Эрдэнэдрилинг” ХХК газрын доорх усны геофизикийн хайгуулын ажил хийх гэрээ байгуулснаас 7 аймгийн 51 сумын 209 цэгт хайгуулын ажил хийж, устай цэг 167 заасан нь устай байх магадлал 83 хувь байна. 2021 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 180.0 сая төгрөгөөр бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай бэлчээрийн 144 /цэг/ газарт шинээр уст цэг тогтоох хайгуулын ажил хийхээр төсвийг тусгаад байна.	90%
26		4.2. Уст цэг тогтоох хайгуул судалгаа, инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулна	2021 - 2024	9.000.0	2020 онд Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор 21 аймгийн 193 сумдад улсын төсвийн 1,670.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 83, гадаадын төсөл, хөтөлбөрийн 3,700.0 сая төгрөгөөр 180, орон нутгийн төсвийн 3,700.0 сая төгрөгөөр 287 инженерийн хийцтэй худаг, малчдын өөрсдийн санаачлагаар 170 гар худаг, нийт 9,000.0 сая төгрөгөөр 550 инженерийн хийцтэй худаг гаргасан нь 825.0 мянган га бэлчээр, 2.7 мянган малчин өрхийн 1.5 сая толгой малын усан хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ болсон.	90%
27		5. Тариалангийн бүс нутгийг түшиглэн сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйг бий болгоно	2021 - 2024		Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг түшиглэн нийт 3000 үнээтэй сүүний чиглэлийн үхрийн 5 аж ахуй байгуулна. Нийт зардал нь 91,000.0 сая төгрөг бөгөөд Беларусь улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжинэ. Уг төслийн хүрээнд жилдээ 18.3 сая литр сүү нийлүүлнэ. 2020 онд төсөл сонгон шалгаруулалт зарлаж (Номун Тал ХХК, Газар-Агро ХХК, Мөнх-Орхон ХХК, Момо-Агро ХХК, Даваанбулаг ХХК)-ийг төсөл хэрэгжүүлэгчээр сонгон шалгуулж, 3 аж ахуйн нэгжийн төсөл хэрэгжүүлэх боломжтой аж ахуйн нэгжүүдийн нөөцөд авсан. Шалгарсан аж ахуйн нэгжүүд ферм барих газрын хөрсний геодозийн шинжилгээ хийлгэсэн. ферм барих барилгын аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хийгдэж байна. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 131 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх гол бүс нутгийн болон	70%

					тариалангийн талбайн хил хязгаарыг тогтоох чиглэлээр Сэлэнгэ аймгийн 17 сумын 56 баг, Дархан-Уул аймгийн 4 сумын 14 багийн нутгийг тариалангийн бүс болгон чөлөөлөх, бэлчээрийн мал аж ахуй эрхлэгчдийг нүүлгэн шилжүүлэх, соён гэгээрүүлэх, мал сүргийг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах, үе шаттай хэрэгжүүлэх зорилгоор орон нутгийн мэргэжлийн байгууллага, аймаг, сумдад чиглэл хүргүүлэх, дэлгэрэнгүй тоон мэдээ, судалгаа авч тариалангийн талбайн хил хязгаарыг тогтоох чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Газар тариалангийн бүс нутагт байгаа бэлчээрийн малаас авах албан татварын хэмжээг толгой тутамд 2000 төгрөг байхаар тооцох шийдвэрийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталж мөрдөх чиглэл өгсөн. Тариалангийн бүсэд хамаарах малчин болон мал бүхий өрх, хуулийн этгээд, тэдгээрийн малын төрөл, тоо, нас, хүйс, өмчлөлийн болон эзэмшлийн өвөлжөө, хаваржаа, худаг уст цэгийн тоо, малын бүлэглэлт зэргийг 2020 оны жилийн эцсийн байдлаар баг, сум, аймгаар гаргуулсан ба цаашид авах арга хэмжээний талаар судалгаа дүгнэлт хийж байна.	
28		6. Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, үйлдвэрлэл эрхлэгчдийн санаачлага, хөрөнгө оруулалтыг урт хугацааны хөнгөлөлттэй зээл, татварын бодлогоор дэмжинэ	2021 - 2024		2020 онд эрчимжсэн аж ахуйн чиглэлээр аймгууд дараах зээл олгосон байна. Өвөрхангай 2020 онд “Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан” болон “Сум хөгжүүлэх сан”-гаас Арвайхээр, Хархорин, Сант, Есөнзүйл, Баян-Өндөр, Зүүнбаян-Улаан, Тарагт, Баруунбаян-Улаан Бат-Өлзий сумын 134 иргэн, аж ахуйн нэгжид 654.0 сая төгрөг, Өмнөговь аймагт ЖДҮХС-аас орон нутгийн хөрөнгөөр хөнгөлөлттэй зээл олгож Гурвантэс суманд сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр "Хөвдийн алтан тоорой" ХХК-нд 48 сая төгрөг, Даланзадгад суманд "Сүүн дэгжих" ХХК-нд 90 сая төгрөг, малын тэжээл үйлдвэрлэлээр Номгон сумын "Бат-Амгалан хөрх" хоршоонд 74 сая, Даланзадгад суманд мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлээр "Тананжин" ХХК-нд 21 сая төгрөгийн зээл олгож, үйл ажиллагааг нь дэмжсэн байна. Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох журмыг боловсруулж Засгийн газрын 130 дугаар тогтоолоор батлуулсан. Журамд заасан шаардлага хангасан сүү боловсруулах 8 үйлдвэрт 11 дүгээр сард 1,939,944.0 литр техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн малын түүхий сүү бэлтгэн нийлүүлсэн Үндэсний статистикийн хорооны 2019 оны мал тооллогын А дансны бүртгэлтэй, сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ сүүний үйлдвэрт нийлүүлсэн сүүгээ и-баримтад бүртгүүлэн баталгаажуулсан 2375 малчин, эрчимжсэн мал аж ахуйн эрхлэгчдэд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А-387 дугаар тушаалын дагуу 969,972,000.0 төгрөгийн урамшуулал олгосон нь эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийг бүртгэх, үйл	70%

					ажиллагааны чиглэлээр төрөлжсөн, ажлын үр дүнгээр урамшуулах арга хэмжээ болсон. Мөн ноос, арьс ширэнд урамшуулал олгож байна.	
29		7. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор бог малыг шахан бордох төвийг орон нутагт туршина	2021 - 2024		Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх зорилгоор бог малыг шахан бордох төвийг Дорнод, Хэнтий, Төв, Сэлэнгэ, Дархан-Уул, Хөвсгөл, Увс аймгууд эрчимтэй дэмжин үйл ажиллагаа явуулж байна. Дархан-Уул аймгийн Орхон суманд “Сонгомол хишигтэн” ХХК Францын суффольк үүлдрийн хонийг монгол хоньтой хээлтүүлэн, махны чиглэлийн түргэн өсөлттэй хонин сүргийн цөм бий болгохоор ажиллаж байна. Суффольк үүлдрийн хонины эрлийз хурга нь хүйтэнд тэсвэртэй учраас манай орны нөхцөлд тохиромжтой бөгөөд гэжээлээр бордвол 8 сартай хурга нь 70 хүртэлх жин татдаг аж. “Сонгомол хишигтэн” ХХК нь одоогоор 750 эм хонь, 7 цэвэр цусны хуцтай үйл ажиллагаа явуулж байна. Малын зохиомол хээлтүүлгийн чиглэлээр өөрийн ажилтныг Өвөрмонголд сургаж, дээрх үүлдрийн хонийг аймаг орон нутагтаа нутагшуулан, технологийн дагуу арчлан маллаж, цэврээр нь үржүүлэхэд технологи, арга зүйн зөвлөмж өгч байна. Тус аймаг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж, 150 гаруй сая төгрөгийн санхүүжилтээр махны болон сүүний чиглэлийн, дэлхийн шилдэг үүлдрийн үхэр авчирч фермерийн аж ахуйгаар өсгөн үржүүлж байна. Бэлчээрийн хомсдол, даац хэтрэлт, малын тооны хэт өсөлт зэрэг нь нөөцийн хязгаарлагдмал байдлыг үүсгэж, МАА-н үйлдвэрлэлийг явуулах арга барилыг өөрчлөн, боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага улам бүр нэмэгдэж байгаа энэ цаг үед малын тооноос илүү чанар, үр ашгийг түлхүү анхаарч эрчимжсэн МАА эрхлэгчдийг аймаг орон нутгийн зүгээс дэмжин ажиллаж байна.	ҮБ-гүй
30	3.3.5. Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, сайжруулалтын хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, бэлчээрийн доройтол, цөлжилтийг бууруулна.	1. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтад, шавжтай байгаль орчинд сөрөг нөлөө багатай аргаар тэмцэнэ	2021 - 2024	4.897.0 /Улсын төсөв/ 971.0 /орон нутгийн төсөв/	ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-52 дугаар тушаалаар 5,000.0 сая төгрөгийг ургамал хамгааллын ажилд зарцуулахаар баталсан. Ургамал хамгааллын арга хэмжээний хуваарийг ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-80, А-89 дүгээр тушаалаар тус тус батлуулан холбогдох аймгуудад хүргүүлэв. Үлийн цагаан оготной тэмцэх ажлын удирдамжийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан мөн аймгуудад хүргүүлсэн. Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх арга хэмжээнд 2020 онд нийт 17 аймгийн 174 гаруй сум, 4 аймаг дундын отрын бүс нутгийн 1.63 сая га бэлчээрийн талбай хамрагдаж үлийн цагаан оготны хөнөөлөөс хамгаалж мал аж ахуйн үйлдвэрлэлд ашиглах боломжийг бүрдүүлж ажиллав. Ингэснээр эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан нийт тэмцэх шаардлагатай талбайн 15.47 хувьд тэмцэх ажил зохион байгуулав. 2020 оны гүйцэтгэл нь өмнөх оноос 600 мянган га, сүүлийн 10 жилийн дунджаас 1.0 сая га талбайгаар тус тус нэмэгдсэн байна. Үлийн цагаан оготны бэлчээрт учруулах хөнөөлийг бууруулах, урьдчилан сэргийлэх	90%

					ажилд орон нутгийн төсвөөс зарцуулах хөрөнгө энэ онд 1,300.0 саятөгрөг болж өссөн дүнтэй байна. Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулдаг царцаатай Баян-Өлгий, Ховд аймгийн тус бүр 20, Говь-Алтай аймгийн 26 мянган га талбайд тэмцэх ажил хэрэгжүүлэхээр ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А-80 дугаар тушаалаар батлуулсан. Царцаатай тэмцэх ажил зохион байгуулах Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймагт нийт 9900 литр ургамал хамгааллын бодис хүргүүлсэн. Бэлчээрийн 66 мянган га талбайн ургамлыг царцааны хөнөөлөөс хамгаалж мал аж ахуйн үйлдвэрлэлд хэвийн ашиглах боломжийг бүрдүүлсэн. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шавж судлалын секторын эрдэмтэд 2020 оны 06 дугаар сарын 8-19-ны өдрүүдэд Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай аймагт царцааны тархалт, хөнөөлийн тодотгох судалгааг гэрээний дагуу стандарт хугацаанд хийж гүйцэтгэсэн бөгөөд 2020 оны байдлаар дээрх аймгуудад царцааны тархалт өмнөх жилийнхээс 1-3 дахин их байгааг судлаачид тогтоосон байна.	
31	3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	1. Малчдын анхдугаар аяныг зохион байгуулна	2021 - 2024		Хугацаа болоогүй 2021 онд зохион байгуулж эхэлнэ	ҮБ-гүй
32	3.3.6. Малчдыг дэмжих анхдугаар аян зохион байгуулж, мал сүргийг гэмт халдлагаас хамгаалж, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг бүсчилсэн байдлаар байгуулан нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн экспортолж, малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлнэ.	2. "Монгол малчин" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021 - 2024		ХХААХҮ-ийн сайдын “Төлөвлөгөө батлах тухай” А-169 дүгээр тушаалаар “Монгол малчин” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /2020-2024 он/ батлуулсан. Тус төлөвлөгөөг 21 аймгийн ХХААГ-г хүргүүлж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2020 оны гуравдугаар улирлын статистик үзүүлэлтээс харахад малчин өрхийн сарын дундаж орлого 1225237 төгрөг болсон нь 3.4 хувиар өссөн байна.	70%
33	3.3.7. Мал аж ахуйг байгаль, цаг уурын эрсдэлээс хамгаалах, бэлэн байдлыг хангах, сумдад өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх, малчдыг өвс тэжээл нөөцлөх сүлжээг бий болгоно.	1. Өвсний нөөц бүрдүүлэх, зориулалттай техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийнэ	2021 - 2024		“Монголын ургамал хамгаалал, хяналт үнэлгээ холбоо” ТББ-тай хамтран “Уургийн өндөр агууламжтай олон наст царгас тариалж малын тэжээлийн нэр төрлөө нэмэгдүүлье” сэдэвт сургалтыг Дархан-Уул, Сэлэнгэ аймаг болон Улаанбаатар хотод 2020 оны 1 дүгээр сард зохион байгуулав. Сургалтад малчид, фермерүүдийн 60 гаруй төлөөлөл хамрагдаж, малын тэжээл тариалах технологийн мэдлэгээ дээшлүүлэв. 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлийг даван туулахад зориулж Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 419, 2020 оны 85 дугаар тогтоолоор 18 аймагт улсын нөөцийн 5771 тн өвсийг үнэгүй, 4759 тн тэжээлийг 50 хувь хямдруулан малчдад, хамгийн эрсдэл өндөртэй 7 аймагт 350.0 сая төгрөг олголоо. Засгийн газрын 138 дугаар тогтоолоор аймаг дундын 7 отрын бүсэд өвөлжиж, хаваржиж буй малчдад зориулсан аюулгүйн нөөцийн ногоон тэжээл 612.5 тн, хивэг 350 тн хивэг худалдан авах 406.0 сая төгрөг шийдвэрлүүлэв. Аюулгүйн нөөцийн ногоон тэжээл, хивэг худалдан авах сонгон	100%

					шалгаруулалтыг зохион байгууллаа. Өвсний нөөц бүрдүүлэх, зориулалттай техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх зориулалтаар 2021 оны төсөвт 200 сая төгрөг төсөвлөөд байна.	
34	3.3.8. Мал эмнэлгийн тогтолцооны шинэчлэлийг төгөлдөржүүлж, халдварт, гоц халдварт өвчинтэй тэмцэх, гоц халдварт өвчингүй, тайван бүсийг баталгаажуулж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний экспортын боломжийг нээнэ.	1. Биокомбинат үйлдвэрийн дэд бүтэц, үйлдвэрийн технологийг шинэчлэнэ	2021 - 2024	-	Монгол улсын Засгийн газар, Унгар улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөр” хэлэлцээрийн хүрээнд Мал эмнэлгийн ерөнхий газар, БНУУ-ын Мегаложистик компани хооронд 2019 онд “Биокомбинат үйлдвэрийн өргөтгөлийн барилга, байгууламжийн зураг төсөл, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх түлхүүр гардуулах нөхцөлтэй гэрээ”, БНУУ-ын Эксим банк Монгол Улсын Сангийн яам хооронд “Санхүүгийн хэлэлцээр”-ийг 2020 оны 04 дүгээр сарын 31-ний өдөр тус тус байгуулсан. "Санхүүгийн хэлэлцээр"-ийн хавсралтад заасны дагуу 2020 оны 07 дугаар сарын 21-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны “хууль зүйн дүгнэлт”-ийг БНУУ-ын талд хүргүүлэн гэрээ хэрэгжиж эхэлсэн байна. Одоогоор тус төслийн хүрээнд Унгарын Мега-ложистик компани шинэ үйлдвэрийн, биоаюулгүй ажиллагааны 3 дугаар зэргийн лабораторийн барилгын зураг төсөв, технологийн зураг хийгдэж байна. Үйлдвэрийн барилгын зураг төсөв нь нарийн төвөгтэй, олон улсын стандартын дагуу хийгдэж буй тул цаг хугацаа нилээд шаардагдаж байна. Төслийн үе шатны ажлын хуваарийн дагуу 2020 оны 11-р сарын 06-ны өдрөөс төслийн ажлыг эхлүүлсэн бөгөөд 2021 оны II улирлаас шинээр баригдах барилгын ажлыг эхлүүлэхээр тохиролцсон. Монгол, Унгарын Засгийн Газар хоорондын Комиссын Монголын хэсгийн дарга ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн, Унгарын хэсгийн дарга Гадаад хэрэг, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Юу Иштван нарын цахим уулзалтыг ГХЯ-тай хамтран зохион байгуулсан. Талууд Биокомбинат үйлдвэрийн иж бүрэн шинэчлэлийг цар тахлын хүнд оновчтой байдлаар хэрхэн урагшлуулах, тулгамдаж буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх, зохион байгуулж ажиллах талаар санал солилцож, айлын талаас Монгол Улсад ирж ажиллах багийн мэдээллийг ирүүлэхээр болсон тул талууд уг асуудлыг судалж байна.	50%
35		2. Малын эмч нарыг чадавхижуулж, мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулна	2021 - 2024	Нийт 301.0 сая төгрөг, үүнээс ШХА-ийн санхүүжилттэй Ногоон алт Малын эрүүл мэнд төслөөс 160.0 сая төгрөг, Орон нутгаас 93.5 сая төгрөг, Хувийн	Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны газар болон МЭЕГ хооронд 2019 оны 08 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан 81061564 дугаартай гэрээний хүрээнд Ногоон алт-Малын эрүүл мэнд төслөөс Архангай аймгийн Их тамир сум, Завхан аймгийн Эрдэнэхайрхан сум, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Баянхонгор аймгийн Баянцагаан, Ховд аймгийн Дарви, Чандмань, Мөнххайрхан, Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Мал эмнэлгийн тасаг, МЭҮН-ийн цогцолбор барилга, байгууламжийн өргөтгөл, засвар, шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх сонгон шалгаруулалт зарлаж, төслөөс нийт 160.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Барилгын ажлууд одоогоор цаг улирлын байлаас	90%

				хөрөнгө оруулалт 47.5 сая төгрөг		болж түр саатаад байна. Өнгөрсөн онд хэрэгжсэн Архангай амгийн Өндөр-Улаан сумын барилга 100 хувь ашиглалтад орж, үйл ажиллагаа жигдэрсэн.	
36		3. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлнэ (Мал, амьтны гоц халдварт болон зооноз өвчнөөс бусад)	2021 - 2024	Орон нутгийн төсөв 7,171.7 сая төгрөг, Хувийн хэвшлээс 410.9 сая төгрөг		Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2020 оны А/43 дугаар тушаалаар баталсан төлөвлөгөөний дагуу орон нутгаас санхүүжүүлэх 9 нэрийн өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 2020 онд 11.6/11.8 сая толгой мал, амьтан хамруулж 98.8, иргэн, хуулийн этгээдээс санхүүжүүлэх 3 нэрийн вакцинд 4.9/5.0 сая толгой мал, амьтан хамруулж 97.7 хувь, нийт 12 нэрийн мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд давхардсан тоогоор 16.5/16.8 сая толгой мал, амьтан хамруулсан. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2020 онд мал, амьтны 8 нэрийн халдварт өвчний голомтын тоо 22.3 хувиар өсч, тохиолдлын тоо 1.1 хувиар буурсан.	70%
37		4. Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлнэ	2021 - 2024	Улсын төсвөөс нийт 15,489.0 сая төгрөг, үүнээс МЭҮН-үүдэд нийт 4,949.0 сая төгрөгийн үйлчилгээний хөлс. Вакцин худалдан авахад 10,540.0 сая төгрөг зарцуулсан.		Мал, амьтны гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд нийт 32,080.7 толгой малыг төлөвлөсөн зураглал /хавсаргасан/-ын дагуу хамруулсан ба нэмэлтээр Архангай зэрэг аймгуудад эрсдэл үүссэн, төлийн тоо болон зүүн аймгууд руу чиглэсэн отор нүүдэл нэмэгдсэнээс дархлаажуулалтын зардал өссөн байна. Монгол улсад 2020 оны 12 дугаар сарын эцсийн байдлаар мал, амьтны гоц халдварт өвчингүй, тайван байна.	90%
38		5. Малын бруцеллөз, боом, галзуу зэрэг зооноз өвчнөөс урьдчилан сэргийлнэ	2021 - 2024	-		Хэнтий, Завхан, Хөвсгөл, Говь-Алтай, Дорноговь, Баянхонгор зэрэг 6 аймгийн 8 суманд боом өвчний 12 голомт, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгаас бусад 17 аймаг, нийслэлийн давхардсан тоогоор 224 суманд мал, амьтны галзуу өвчний 279 голомт бүртгэгдсэн. Боом, галзуу, бруцеллөз, шувууны тахал, листериоз зэрэг 5 нэрийн зооноз өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад 22.5/23.3 сая толгой мал, амьтан хамруулж 96.8 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлсэн байна. Бүртгэгдсэн голомтын тоо 35.5 хувиар, бүртгэгдсэн тохиолдлын тоо 16.5 хувиар тус тус өссөн байна.	70%
39		6. Мал эмнэлэг, хүнсний аюулгүй байдлын лаборатори, чанарын дэд бүтцийг сайжруулах, чадавхижуулна	2021 - 2024	Улсын төсөв: 1,352.4 сая төгрөг, Төслөөс 29.0 сая төгрөг,		Лабораторийн оношилгооны бэлэн байдлыг хангах, оношилгооны чадавхыг сайжруулах зорилгоор малын бруцеллөзын вакцинжуулалтын дараах хяналт, тандалтад хэрэглэх оношлуур хэрэглэгдхүүн авахад 23,172,000.0, шувууны томуу өвчний тандалтад хэрэглэх урвалж, хэрэглэгдхүүн авахад 19,600,000.0, малын эмийн үлдэгдлийн шинжилгээний оношлуур, хэрэглэгдхүүн худалдан авахад 39,390,000.0, мал эмнэлгийн анхан шатны лабораторид ашиглах материал, оношлуур авахад 41,150,000.0 төгрөгөөр худалдан авч	90%

					ашиглаж байна. Лабораторийн техник тоног төхөөрөмжийг сайжруулах зорилгоор Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторит тоног төхөөрөмж нийлүүлэх МЭТШ/2020_01 дугаартай тендерээр 20 нэр төрлийн 32 ширхэг 370,713,650.14 төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч ашиглаж байна. Лабораторийн шинжилгээний цахим гүйцэтгэлийг сайжруулах зорилгоор УМЭАЦТЛ-ийн vet.shinjilgee.mn системд мэдээлэл технологийн сүлжээний программ өргөтгөх 29,000,000.0 төсөвт өртөгтэй ажлыг Дижитал медик ХХК-аар гүйцэтгүүлэн амжилттай ашиглаж байна.	
40		7. Монгол Улсыг үхрийн цээж, ямааны годрон, үхрийн тархи сархиагтах өвчингүй, тайван байдлыг ДМАЭМБ-аар баталгаажуулна	2021 - 2024	Улсын төсвийн 195.0 сая төгрөг	Үхрийн цээж, ямааны годрон өвчнөөс эрүүлийг баталгаажуулах шинжилгээг МЭЕГ-ын захиалгаар Мал эмнэлгийн хүрээлэнгийн судалгааны баг 2018 оноос хойш хийж жил бүр гүйцэтгэж байна. Уг тандалтаар 2020 онд үхрийн цээжийн ийдлсийн 10090, эдийн 267, ямааны годронгийн ийдлсийн 7769, эдийн 450 сорьц тус тус шинжилснээс эерэг үр дүн бүхий үхрийн ийдлсийн 4, ямааны ийдлсийн 10 сорьцын баталгаажуулах шинжилгээг хийж байна. "Үхрийн тархи сархиагтах" өвчний тандалт шинжилгээг 2012 оноос хойш ХХААХҮЯ-ны захиалгын дагуу УМЭАЦТЛ нь махны үйлдвэрүүдэд тулгуурлан хэрэгжүүлсээр ирсэн. ДМАЭМБ-аас зөвлөсөн аргачлалын дагуу Сэлэнгэ, Хөвсгөл, Архангай, Завхан, Өвөрхангай, Булган аймгийн мал нядалгааны газруудаас 2020 онд авсан нийт 270 тархины сорьцод үүсгэгч /ҮТСЭ-ийн прион/ илрүүлэх ЭЛИЗА урвалын шинжилгээг хийсэн. Лабораторийн шинжилгээгээр бүх сорьцод прион уураг илрээгүй байна. /ЭЛИЗА урвалын үр дүн 100% сөрөг/. Судалгааны үр дүнгүүдийг нэгтгэсний дараа 2021 онд тус өвчнүүдээр Монгол Улсын өвчингүй, тайван байдлыг баталгаажуулах хүсэлтийг ДМАЭМБ-д өргөн мэдүүлэхээр бэлтгэж байна.	70%
41		8. Шүлхий өвчингүй, тайван байдлыг баталгаажуулна	2021 - 2024	Улсын төсвийн 161.8 сая төгрөг	Гоц халдварт шүлхий өвчний халдвар илрүүлэх тандалтыг улсын хэмжээнд 2009 оноос бүх аймгийг хамруулан нэгэн зэрэг явуулсаар байгаа бөгөөд 2020 онд баруун, төвийн, зүүн бүсээр хуваан, нийт 13170 толгой мал сүргийг хамруулсан. Баруун бүсийн 7 аймагт хийсэн шүлхийн тандалт шинжилгээний шүлхий өвчний ББУ-ийн эсрэгбием болон молекул биологийн шинжилгээгээр үүсгэгчийн генийн өвөрмөц хэсэг болон ББУ-н эсрэгбием илрээгүй /халдварлалт хувь 0/. Төвийн бүсийн 10 аймагт хийсэн илрүүлэх шинжилгээний үр дүнд 10 сорьц эерэг (Төв-2, Дархан-Уул-2, Улаанбаатар-6) буюу шүлхий өвчний ББУ-ийн эсрэгбием илэрсэн. Баталгаажуулах шинжилгээгээр Төв болон Дархан-Уул аймгаас ирүүлсэн давтан сорьцод шүлхийн вирусын генийн өвөрмөц хэсэг илрээгүй /халдварлалтын хувь 0.13/. Зүүн бүсийн 5 аймагт хийсэн шинжилгээний үр дүнд 122 сорьц эерэг (Сүхбаатар-64, Хэнтий-6, Дорнод-4, Дорноговь 48) буюу шүлхий өвчний ББУ-ийн эсрэгбием илрэв /зүүн бүсийн халдварлалтын хувь	70%

					5.15 (122/2370)/. УМЭАЦТЛ-т хийсэн баталгаажуулах шинжилгээгээр 128/13170 сорьцын эерэг үр дүнг баталгаажуулснаар, улсын хэмжээгээр шүлхий өвчний халдварлалт 0,97%-тай байна. Монгол улсын баруун бүс буюу Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Говь-Алтай, Баянхонгор, Хөвсгөл аймгийг шүлхийгүй, вакцин хэрэглэдэггүй бүс болохыг ДМАЭМБ-аар хүлээн зөвшөөрүүлэхээр илгээх баримт бичиг (dossier)-ийг 2020 оны 09 дүгээр сард МЭЕГ-ын албан ёсны цахим хаягаар дамжуулан ДМАЭМБ-ын захирлын болон холбогдох цахим хаягуудаар илгээсэн, хүлээгдэж байна.	
42	3.3.9. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар мах, ноос, ноолуур, арьс шир боловсруулах үйлдвэрийн бүтээмжийг нэмэгдүүлнэ.	1. Боловсруулах үйлдвэрлэлийн бүтээмжийг дээшлүүлэх дэвшилтэт технологи, инноваци нэвтрүүлэх хөнгөн үйлдвэрийн салбарын лаборатори, төвүүдийн чадавхыг сайжруулна	2021 - 2024	127.6 сая төг- Гадаадын төслөөс	Төрөөс 2020-2024 онд хөнгөн үйлдвэрлэлийг тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилгоор Салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, шинэ, дэвшилтэт болон өндөр технологи нэвтрүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл, импортыг орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, хог хаягдал, дахин боловсруулах үйлдвэрлэл хөгжүүлэх, экспортын хэмжээг нэмэгдүүлэх зорилтууд тавьсан. Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд арьс шир, ноос ноолуурын салбарын техник технологийн хүрсэн түвшинг тогтоох, тулгарч буй асуудал, гарц шийдэл, R&D судалгаа хөгжүүлэлт, инновац дамжуулалтын чиглэлийг тодорхойлох, дотоод ба гадаад хамтын ажиллагааг уялдуулан өргөжүүлэх ХХААХҮ-ийн Судалгаа хөгжлийн төвийг Засгийн газрын 2020 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн 93 дугаар тогтоолоор байгуулсан. “Монгол Улсад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих (SECiMC2)” төслийн хүрээнд “Сүлжмэлийн гүйцэтгэн боловсруулалтын инкубатор” сургалтын төвийг Хөнгөн үйлдвэрийн судалгаа, хөгжлийн хүрээлэн дээр байгуулж чадавхыг сайжруулав. Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил төслийн шугамаар Монголын ноос, ноолуурын холбооны дэргэд баталгаажуулалтын алба байгуулсан. Тус “Баталгаажуулалтын алба” нь олон улсын MNS ISO/IEC17065 стандартын шаардлагыг бүрэн хангасан тул үндэсний болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй Монгол Улсын ноос ноолуурын салбарын “Тохирлын үнэлгээ-Бүтээгдэхүүн, үйл явц, үйлчилгээний баталгаажуулалт”-ыг явуулах эрх бүхий байгууллага болсон. Мөн тус төслийн хүрээнд Хөнгөн үйлдвэрийн судалгаа хөгжлийн хүрээлэнгийн “Нэхмэлийн гүйцэтгэн боловсруулалтын сургалтын материаллаг бааз тоног төхөөрөмж бүхий төв” байгуулан чадавхыг сайжруулав.	100%
43		2. Ноос, ноолуурын салбарын эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх хөрөнгө	2021 - 2024	5,062.7 сая төг- хүүгийн хөнгөлөлт, 5 сая ам.долл-хувийн хэвшил	Гоёл кашимер ХХК нь АНУ-ын DFC банкнаас 5 сая ам. долларын зээлийн хөрөнгө оруулалтаар шинэ үйлдвэрийн байр ашиглалтад оруулж, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийсэн. Европын холбооны Трам төсөлтэй хамтран сарлагийн хөөвөр боловсруулах чиглэлээр загвар төслөөс Жинст мөрөн ХХК, Сноу филдс ХХК, Мөнхбумууд ХХК, Бест кашемир ХХК, Уужин ХХК, Сор кашемир ХХК зэрэг	100%



		оруулалтын төсөл хэрэгжүүлнэ.				үйлдвэрүүд кластерын зарчмаар ажиллах загвар хэрэгжүүлж, бүтээгдэхүүнээ Европт гаргах эхлэлийг тавьж, Герман улсад бараа бүтээгдэхүүнийг борлуулах дэлгүүрийг 2020.11.20-нд нээхэд дэмжлэг үзүүлсэн. Тус дэлгүүрийн 7 сар хүртэлх түрээсийн төлбөрийг төслөөс санхүүжүүлж байна. Дэлгүүр нь Ковид-19 -оос шалтгаалж үйл ажиллагаагаа түр зогсоосон байна. 2020 онд 44 аж ахуйн нэгжид 103,9 тэрбум төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг ноолуур бэлтгэлийн зориулалтаар олгосон. ХХААХҮЯ-наас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр 9 хувийн хүүгийн хөнгөлөлт болох 5,062.7 сая төгрөгийг Монгол Улсын Хөгжлийн банкинд шилжүүлсэн.	
44	3.3.10. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах байгальд ээлтэй цогцолбор байгуулж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	1. "Дархан арьс ширний цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк(ҮТП)-ийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	2021 - 2024	42,120.0 сая төг-хувийн хэвшлээс		Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд: 1. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн хуралдаанаар “Төрийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай” 185 дугаар тогтоол (Хавсралт 1), 2. Засгийн газрын 2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн дүрэм батлах тухай 2020 оны 234 дугаар тогтоол (Хавсралт 2), гүйцэтгэх захирлыг томилон, Компанийн гэрчилгээ, тамгыг авч үйл ажиллагааг эрчимжүүлж байна. 3. УИХ-ын 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг тус тус үндэслэн “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Цогцолборын бүтээн байгуулалтад нийт 42.12 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс оруулаад байна.	70%
45		3. Түүхий эд бэлтгэлийн зориулалтаар хөрөнгө оруулалт, эргэлтийн хөрөнгийн нэн хөнгөлөлттэй зээлийг Аж ахуй нэгжүүдэд олгоно.	2021 - 2024	МУХБ-аас 103,900.0 сая төг Хүүгийн хөнгөлөлтөд- 5,062.7 сая төг		Үйлдвэрүүдэд ноолуур бэлтгэлийн зориулалтаар 2020 онд 44 аж ахуйн нэгжид 103,900.0 сая төгрөгийн хүүгийн хөнгөлөлттэй зээлийг МУХБ-наас олгосон. ХХААХҮЯ-наас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр 9 хувийн хүүгийн хөнгөлөлт болох 5,062.7 сая төгрөгийг МУХБ-д шилжүүлсэн.	90%
46	3.3.11. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үндэсний үйлдвэрт бүтээгдэхүүнээ нийлүүлсэн	1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд төрөөс олгох татаас, мөнгөн урамшууллын тогтолцоог	2021 - 2024	9,913.0 сая төг - арьс ширний урамшуулалд, 12,900.0 сая төг-ноосны		УИХ-ын 2020 оны 32, ЗГ-ын 2020 оны 167 дугаар тогтоолоор 2019 оны жилийн эцсийн мал тооллогоор А дансанд бүртгэгдсэн мэдээлэлд үндэслэн, бэлтгэсэн нэг килограмм ноолуур тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгохоор баталж, нэг ямааны ноолуурын гарцыг дунджаар 300 гр-аар тооцон 203 641 малчин, мал бүхий этгээдэд 175	100%

	малчид, тариаланчдад төрөөс урамшуулал олгоно.	бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн үр дүнтэй холбож боловсронгуй болгоно		урамшуулалд, 174,909.6 сая төг-ноолуурын урамшуулалд, 969.97 сая төг-сүүний урамшуулалд, 23,900.0 сая төг-буудайн урамшуулалд		тэрбум төгрөгийн урамшуулал олгосон. Үндэсний үйлдвэрүүдийг түүхий эдээр хангах, нөгөө талаас малчдын орлогыг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 37,825 малчин /2,610,197 ширхэг арьс ширэн түүхий эд/-д 9.9 тэрбум, 49,625 малчин /11.5 мян.тн ноос/-д 12.9 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон. Түүхий эдийн бэлтгэлд ангилал, зэрэглэлийн дагуу ялгавартай үнийг тогтоож, чанарыг үнэлэх систем рүү шилжүүлэхээр малчдын QR код, арьс шир, ноос ноолуурын чанартай уялдуулан Урамшууллын журамд өөрчлөлт оруулж, яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанд оруулахаар ажиллаж байна. Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд гарал үүсэл нь баталгаажсан эрүүл малыг, техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүүг нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид мөнгөн урамшуулал олгох” журам батлуулсан. Сүүний 8 үйлдвэрт 1,939,944.0 литр түүхий сүү нийлүүлсэн 2375 малчин, ЭМАА эрхлэгчдэд 969,97 сая төгрөгийн урамшуулал олгосон. Тариаланчдад нийт 23,900.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. Тариаланчдад олгох буудайн урамшууллын журмыг шинэчлэн боловсруулж байна.	
47	3.3.12. Хөдөө аж ахуйн тээвэр, борлуулалтын логистикийн сүлжээг байгуулж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн чанарын хяналт, баталгаажуулалтын оновчтой тогтолцоог бүрдүүлнэ.	1. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний хадгалалт борлуулалтын цогцолбор төвүүдийг Улаанбаатар хот, бүсүүдэд байгуулна	2021 - 2024			1. Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, махны хадгалалт борлуулалтын цогцолбор төвийн 2018-2019 онд ТЭЗҮ-ийг хийсэн, байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийсэн, газрын асуудлыг Нийслэлийн Захирагчийн ажлын албанаас шийдвэрлэсэн. Зураг төсөл хийгдэж байна. 2. Монгол Улс - БНПУ-ын Засгийн газар хооронд Монгол Улсад “Хүнсний ногооны үйлдвэрлэлд нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх” 10.2 сая еврогийн санхүүжилттэй төслийг 2 багц буюу А. Багц 1. Төмс, хүнсний ногооны агуулах байгуулах ажлыг 7.0 сая еврогоор 5 аймаг, нийслэлд нийт 6 байршилд 8500 тонн багтаамжтай иж бүрэн механикжсан агуулахыг байгуулахаар төлөвлөсөн. Б.Багц 2. Хүнсний ногооны үйлдвэрлэлд зориулсан трактор,техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийг 3.2 сая еврогоор хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. 3. Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газрын хөнгөлттэй зээлээр барих төмс, хүнсний ногооны агуулахын танилцуулгыг боловсруулан холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан.	70%
48		2. Мал аж ахуйн үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэх, анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч малчин өрхийн үйлдвэрлэж буй түүхий	2021 - 2024			Малчдын бэлтгэн нийлүүлж байгаа бүтээгдэхүүн, түүхий эдийн гарал үүсэл, чанарыг баталгаажуулах, ХАА-н биржээр дамжуулан борлуулах нэгдсэн сүлжээнд хамруулах зорилгоор ХХААХҮЯ-наас 170,0 гаруй мянган малчин өрхийг үндэсний үйлдвэрлэгчээр бүртгэх, гэрчилгээ, баталгааны тэмдэг олгох ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Хүнсний боловсруулах салбарт Үйлдвэрлэлийн	90%

		эд, бүтээгдэхүүний гарал үүслийг баталгаажуулах тогтолцоог бүрдүүлнэ			зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврын төслийг эцэслэн боловсруулж, ХХААХҮ-ийн Сайдын зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн хуралд хэлэлцүүлж дэмжигдсэн. Зааврын төсөлд МХЕГ, СХЗГ-ын саналыг тусгасан, ЭМЯ-наас хамтран батлахаа мэдэгдсэн албан тоотыг ирүүлсэн. Зааврын төсөлд ҮАБЗ-ийн ажлын албаны референтийн ирүүлсэн саналыг тусгаж байна. Зааврын төслийг ХХААХҮ-ийн болон ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлуулахаар бэлэн болгосон. Тус зааврын төслийн салбарын хууль тогтоомж, холбогдох журмуудтай нийцлийг хянаж байна. ХХААХҮЯ-наас нийслэлийн хүн амын 2019-2020 оны хаврын улирлын махны хэрэгцээнд зориулан мал, мах бэлтгэж, нөөцлөх, худалдан борлуулах арга хэмжээнд оролцсон 9 аж ахуйн нэгжтэй "Мал, мах бэлтгэх, махны нөөц бүрдүүлэх, түүнийг хадгалах, худалдан борлуулахад хяналт тавих гэрээ"-г байгуулсан.	
49		3. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг Хөдөө аж ахуйн бирж, хоршооны бүтцэд тулгуурлан боловсронгуй болгож, Загвар хоршоодыг байгуулна	2021 - 2024	280.2 сая төг-гадаадын төслөөс	АХБ-ны санхүүжилтээр Архангай аймгийн Өлзийт, Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд МАА-н загвар хоршоог байгуулах, малчдын хоршилт, хамтын ажиллагааг бэхжүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэл, бэлчээр, усны менежмент, бүтээгдэхүүний өртгийн сүлжээ, зах зээлтэй холбогдсон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах зорилго бүхий "Хоршоонд суурилсан ХАА-н тогтвортой хөгжил" төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Хоршооны сайжруулсан загварын санал бүхий Оношилгооны тайланг АХБ-д 2020.07.09-нд хүлээлгэн өгсөн. Тайланд АХБ-аас ирүүлсэн саналын дагуу сайжруулсан тайланг 2020.08.17-нд хүлээлгэн өгсөн. АХБ-ны Монгол дахь төлөөлөгчийн газрын оффист 2020.10.28-нд төслийн онлайн уулзалтаар олон улсын зөвлөх ажлын үр дүнгээ танилцуулсан. Олон улсын зөвлөх бэлчээрийн даац хэтрэн тахлагдаж байгаа болон өнөөгийн МАА-д зонхилж байгаа өрхийн аж ахуйн султалыг олон улсын туршлагыг судлах, эдгээртэй холбогдуулан асуудлуудыг шийдэх практик гарцыг тодорхойлох, түүнчлэн бэлчээр, хоршоо, малчны татварын хуулийн төслүүд дээр ажиллах, сайжруулах зөвлөмж өгсөн. Уулзалтаар Ковид-19 цар тахал болон төслийн завсрын үр дүнгийн тайлангуудыг хүлээж авах явц удааширч байгаагаар холбогдуулан төслөөр төлөвлөсөн үндсэн ажлуудыг 2021 онд багтаан дуусгахаар шийдвэрлэсэн. Төслийн 2 суманд хийх сургалт, судалгааны ажлыг эхлүүлсэн. НҮБ-ын ХХААБ-ын санхүүжилтээр сүү бэлтгэн нийлүүлэгчдийг хоршоо болгон, хоршоо бүрийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, сүүний чанарыг сайжруулах, хөдөө аж ахуйн зохистой дадлыг хоршооны оролцогч бүр фермдээ нэвтрүүлэх, үйлдвэрт чанартай сүү нийлүүлэх зорилгоор орчин цагийн сүү бэлтгэн нийлүүлэлтийн анхны загвар хоршоог Сонгинохайрхан дүүргийн Ар гүнтийн аманд байгуулсан. Үүнд 30	70%

						гаруй иргэн, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч хоршоонд нэгдэж, уг хоршоо нь өнгөрсөн онд 20.2 сая.литр түүхий сүү үйлдвэрт тушаасан байна.	
50	3.3.13. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг төрөөс бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлого хэрэгжүүлнэ.	1. Экспортын чиглэлийн үйлдвэр эрхлэгчдэд даатгалын үйлчилгээг нэвтрүүлнэ	2021 - 2024	-		Хэрэгжих хугацаа болоогүй	ҮБ-гүй
51		2. Жижиг, дунд үйлдвэрүүдийг дэмжих, ажлын байр бий болгох, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих зээл, санхүүжилтийн бодлого хэрэгжүүлнэ	2021 - 2024	22,547 сая төгрөг		Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь 2020 онд эргэн төлөлтийн эх үүсвэрийн хүрээнд төсөл хүлээн авах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 1579 төслийн 238,4 тэрбум төгрөгийн зээлийн хүсэлт хүлээн авч 249 аж ахуйн нэгжийг 22,9 тэрбум төгрөгөөр дэмжиж, 1497 шинэ ажлын байрыг бий болгов. Энэхүү шинэ ажлын байрны тоог 2019 онтой харьцуулахад 49,6 хувиар бага байгаа нь улсын төсөвт Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг тусгаагүй, Ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд, ХХААХҮ-ийн Сайдын “Зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах” талаар гаргасан 2020 оны А-83, А-373 дугаар тушаалын хэрэгжилтийн улмаас төлөвлөсөн эргэн төлөлтийн орлого буурсантай холбоотой юм. ЗГ-ын тогтоолоор Зээлийн эргэн төлөлтийг 2020 оны 7 дугаар сарын 01 хүртэл хойшлуулсан.	70%
52		3. Орон нутгийн түүхий эдийн нөөцөд тулгуурлан "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" аяныг зохион байгуулах тогтолцоог сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлнэ	2021 - 2024	-		Жижиг, дунд үйлдвэрийн газрын 2020 оны А-54 дүгээр тушаалаар "Нэг суурин-Нэг бүтээгдэхүүн" аяныг зохион байгуулах тушаал гарч, орон нутагт төсөв хуваарилсан боловч төсвийн хүрэлцээгүй байдал, ковидын нөхцөл байдлын улмаас төлөвлөсөн үйл ажиллагаа тасалдсан.	ҮБ-гүйгүй
53	3.3.14. Оюутолгой, Эрдэнэт зэрэг томоохон үйлдвэрийн захиалгат ажлыг үндэсний жижиг, дунд бизнес эрхлэгчид гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлнэ.	1. Үндэсний бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөр, төрийн байгууллага, томоохон аж ахуйн нэгжүүдэд чанар стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх тогтолцоог хөгжүүлэх,	2021 - 2024	-		1. “Оюу толгой” компани “Монголд үйлдвэрлэв” худалдан авалтын стратегийн хүрээнд “Хос-Аз” ХХК-тай хөдөлмөр хамгааллын гутал ханган нийлүүлэх 3 жилийн хугацаатай, 2.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулж, жилдээ “S3” олон улсын стандартын шаардлага хангасан хөдөлмөр хамгааллын 5,000 хос гутлыг нийлүүлж байна. - Дархан минж ХХК нь “Оюу толгой” компанид сард 15000 ширхэг ажлын арьсан бээлийг тогтмол нийлүүлж байна. - Уул уурхайн зориулалт бүхий хүнд даацын шуудайн "Шинэ гантиг" ХХК, "Цасода пластик" ХХК, "Минерал байг" ХХК нь "Эрдэнэт Үйлдвэр" ТӨҮГ, "Оюу толгой" ХХК-тай баяжмал савлах зориулалттай шуудай, бэлдэц материалыг нийлүүлэх гэрээ байгуулан, гэрээний дагуу нийлүүлж	70%

		хэрэглэгч, үйлдвэрлэгчийг холбоно				байна. - "ISO 9001-2015 Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо" стандартыг Мон-Ирээдүй" ХХК арьс шир боловсруулах үйлдвэр, "Бест Шүес" ХХК гутлын үйлдвэр, Дархан Нэхий ХК нэхий, арьс шир боловсруулах үйлдвэрүүдэд нэвтрүүлж, баталгаажуулалтын гэрчилгээг 2020.10.21-ны өдөр ХХААХҮЯ-нд гардуулав. - Органик болон байгалийн гаралтай гоо сайхны бүтээгдэхүүний орц найрлагад тавигдах шаардлагын тухай олон улсын ISO 16128 стандарт, ОУ-ын чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэлд нэвтрүүллээ. 2. Үндэсний бүтээн байгуулалтын томоохон төсөл хөтөлбөр, төрийн байгууллага, томоохон ААН-дэд чанар стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүнийг ханган нийлүүлэх тогтолцоог хөгжүүлэх хүрээнд ЖДҮ үйлчилгээ эрхлэгчийн бүтээгдэхүүн үйлчилгээг стандартын тохирлын үнэлгээнд хамруулах, үнэлгээчин аудитор бэлтгэх сургалтыг 2020.11.25-12.04 өдрүүдэд зохион байгуулж нийслэл, аймаг, сум дүүргийн жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан 45 албан хаагчдыг бэлтгэн албан ёсны эрхтэй тохирлын үнэлгээний шинжээчээр бэлтгэлээ. Үүний үр дүнд ТБОНӨХБАҮХАТХ-ийн хүрээнд ЖДҮ эрхлэгчид орон нутагтаа бүтээгдэхүүн үйлчилгээгээ тохирлын үнэлгээ хийлгэж баталгаажуулан төрийн байгууллагын худалдан авалтанд шууд нийлүүлэх боломж бүрдлээ.	
54	3.3.15. Төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурласан, байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	2. Байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хий багатай ногоон төслүүдийг санхүүжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулна	2021 - 2024	900.0 сая төг-гадаадын төслөөс		Тайлант онд Жайкагийн "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах Хоёр-үе шаттай зээлийн төсөл"-ийн ЖДҮ-ийг хөгжүүлэх 27 төслийн 14.8 тэрбум төгрөг, Байгаль орчны 2 төслийг 900.0 сая төгрөгөөр тус тус санхүүжүүлсэн байна. Улаанбаатар хотод 18 төсөл, орон нутагт 11 төслийг санхүүжүүлэв.	70%
55	3.7.11. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлж, ашиглалтын дэвшилтэт техник, технологи нэвтрүүлнэ.	7. Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлнэ.	2020 - 2023	-		Дархан хотын арьс ширний үйлдвэрлэл технологийн паркийн цэвэрлэх байгууламж шинээр барих ажилд дэмжлэг үзүүлэх ажлын хүрээнд: 1) Дархан арьс ширний цогцолборын дэд бүтцийн бүтээн байгуулалт 14 барилга, байгууламж, ажил хийгдэхээс 4 ажил хийгдэж 22.9%-тай (36.63 тэрбум төгрөг) байна. Тодруулбал: Арьс ширний үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламжын барилга 63.4% (7.76 тэрбум төгрөг), тоног төхөөрөмж 30.9% (7.91 тэрбум төгрөг) байна. 2) Төрөөс Дархан арьс ширний цогцолбор төслийн дэд бүтцийн бүтээн байгуулалтад дэмжлэг үзүүлж олон улсад өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, төсөл амжилттай хэрэгжих нөхцлийг бүрдүүлэхээр Дархан арьс ширний цогцолборын дэд	70%

					<p>бүтцийн бүтээн байгуулалт ТӨХХК-ийг Засгийн газрын 2020 оны 185 дугаар тогтоолоор байгуулсан.</p> <p>3). “Дархан арьс ширний цогцолборын бүтээн байгуулалт” ТӨХХК-ийн дүрмийг Засгийн газрын 2020 оны 234 дугаар тогтоолоор баталсан. Одоогийн байдлаар Гүйцэтгэх захирал томилогдон компаний гэрчилгээ, тамга тэмдгийг авч үйл ажиллагааг эрчимжүүлээд байна.</p> <p>4). 2020 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Гаалийн албан татварыг хөнгөлөх тухай хуулийг тус тус үндэслэн “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдуудаас саналыг авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. Үүнд Дархан-Уул аймагт барих Дархан арьс ширний цогцолборын арьс, шир боловсруулах үйлдвэрийн бохир ус цэвэрлэх байгууламж дэд бүтцийн үндсэн хөрөнгөд бүртгэгдэх импортоор оруулах тоног төхөөрөмжүүд багтаж байгаа болно.</p>	
--	--	--	--	--	---	--

ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

56	<p>4.2.5. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.</p>	<p>3. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.</p>	2021 - 2024	Яамны зарцуулсан төсөв: 2.320 сая	<p>1. Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Сургалтын болон нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан 2018 онд Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлуулав. Хөтөлбөрийн дагуу жил бүр төлөвлөгөө боловсруулж, батлуулан ажиллаж байна. Ёс зүйн зөвлөлийн хуралдааныг 2020 оны жилийн эцсийн байдлаар 2 удаа хуралдуулж, ёс зүйн зөрчил гаргасан болон Төрийн албаны тухай хууль, албан тушаалын тодорхойлолт дахь чиг үүргийг хангалтгүй биелүүлсэн төрийн захиргааны 6, төрийн үйлчилгээний 1 албан хаагчид удирдлагын санаачлагаар, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийг үндэслэн сахилгын шийтгэл ногдуулсан байна. Худалдан авах ажиллагааны сургалт, зөвлөгөө өгөх төвтэй хамтран Худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшүүлэх сургалтад Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны А-96 дугаар тушаалаар 14 албан хаагчийг, мөн А-292 дугаар тушаалаар 15 албан хаагч тус тус хамруулав. Төрийн албаны тухай хууль түүнийг даган гарсан дүрэм журмын өөрчлөлттэй уялдуулан хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулахаар 2021 оны төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.</p> <p>2. Засгийн газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийн газрыг байгуулан Жижиг, дунд үйлдвэрийн газрын Даргын 2020 оны А-23 тоот тушаалаар Ёс зүйн зөвлөлийг байгуулсан. Засгийн газрын 2019 оны "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлах тухай" 33 дугаар тогтоолын</p>	70%
----	---	---	-------------	-----------------------------------	---	-----

					хүрээнд байгууллагын ажилтан албан хаагчдад ёс зүйн дүрмийг танилцуулсан.	
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО						
57	5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлого хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3 хувиар бууруулна.	2. Уур амьсгалын өөрчлөлтийн Парисын хэлэлцээрт оруулах үндэсний тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангана.	2020 - 2024		Монгол улсад байгаль орчинд ээлтэй, хүлэмжийн хийн ялгаруулалтыг 30 хүртэлх хувиар бууруулдаг "Органик" хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор Органик хүнсний тухай хууль, дагалдан гарах 4 журам, 1 зөвшөөрөгдөх бодисын жагсаалт, 1 аргачлал тус тус батлан мөрдөж байна. Органик хүнсний бүртгэл, мэдээллийн санд 2020 оны жилийн эцсийн байдлаар шилжилтийн үеийн 226, органик 379, импортын 23 бүтээгдэхүүн тус тус бүртгэгдэж, зах зээлд нийлүүлэгдсэн байна. Хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар Дахин боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк төслийг хувийн хэвшилтэй хамтран хэрэгжүүлж байна. Тус паркийн эхний үйлдвэрүүдийг байгуулж эхлээд байна. Мөн шингэн хог хаягдлыг боловсруулж цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэр байгуулахаар Засгийн газраас концессийн гэрээ байгуулсан. Боловсруулах үйлдвэрүүдэд байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологи нэвтрүүлэх, импортыг орлох, экспортын баримжаатай үйлдвэрлэлийг дэмжих, тоног төхөөрөмж худалдан авах болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэр бий болгох зорилгоор Азийн хөгжлийн банк, Жайка төсөлтэй хамтран ажиллаж байна. Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар БХЯ-ны Зэвсэгт хүчний жанжин штабын дэргэд Ойн цэвэрлэгээ хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг бүтээн байгуулалтад оролцуулах төслийн баг байгуулан ажиллаж байна. Ойн цэвэрлэгээний ажилд шаардлагатай мэргэжилтэй боловсон хүчин, бригад, техник тоног төхөөрөмжийн судалгааг БХЯ-ны Жанжин штабтай хамтран боловсруулж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг Беларусь, БНХАУ-ын буцалтгүй тусламжаас шийдэрлүүлэхээр төсөл боловсруулж, БХЯ-нд танилцуулсан. Ойн цэвэрлэгээний ажлыг гүйцэтгэх бүс нутгийг сонгон, ойн нөөцийг тодорхойлж, дэд бүтцийн ажлын өртөг зардлын тооцоог хийж, техник технологийн сонголтыг мэргэжлийн зөвлөх баг гүйцэтгэсэн.	70%